



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫГ ХУУЛЬ, ЖУРАМД НИЙЦҮҮЛЭН
ТӨВЛӨРҮҮЛЖ, ЗАРЦУУЛСАН Ч ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

АУДИТЫН НЭР: Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт

АУДИТЫН КОД: УВА-2025/27-18-ШТА-ГА

Улаангом хот 2025 он

Дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь

Утас: 70453317 Цахим хаяг: Batsuunm@audit.gov.mn

Аудитын менежер М.Бат-Амгалан

Утас: 70453317 Цахим хаяг: Batamgalanm@audit.gov.mn

Ахлах аудитор Т.Намжил

Утас: 70453317 Цахим хаяг: Namjilt@audit.gov.mn

Ахлах аудитор Ч.Мөнхтогтох

Утас: 70453317 Цахим хаяг: Munkhtogtokhch@audit.gov.mn

Аудитор Т.Амармэнд

Утас: 70453317 Цахим хаяг: Amarmendt@audit.gov.mn

Аудитор Б.Нямбуу

Утас: 70453317 Цахим хаяг: Nyambuub@audit.gov.mn

Аудитор Т.Ариунсаихан

Утас: 70453317 Цахим хаяг: Ariunsaikhant@audit.gov.mn

Аудитор Л.Шагдарсүрэн

Утас: 70453317 Цахим хаяг: Shagdarsuren1@audit.gov.mn

**АГУУЛГА**

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	5
ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ	6
ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ	6
Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх	7
Аудитын зорилт	7
Аудитын хамарсан хүрээ	7
Аудитын арга зүй	7
Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн, хугацаа	8
Аудитын дүн	8
Ерөнхий мэдээлэл	8
БҮЛЭГ 1. Торгуулийн орлогыг хуулийн хүрээнд төлөвлөсөн ч өмнөх оны гүйцэтгэлд үндэслээгүй, хүүгийн орлогыг төлөвлөөгүй байна.	9
1.1. Хүүгийн орлогыг төлөвлөөгүй, торгуулийн орлогын төлөвлөлт нь бодит хэрэгцээ шаардлагад нийцсэн байна.	9
1.1.1. Хүүгийн орлогыг төлөвлөөгүй байна.	9
1.1.2. Торгуулийн орлогыг төлөвлөх бодит хэрэгцээ шаардлагатай байна.	10
1.2. Хүү, торгуулийн орлогыг гүйцэтгэлд үндэслэн төлөвлөөгүй байна.	12
1.2.1. Торгуулийн орлогын төлөвлөгөөг 2022-2024 онд давуулан биелүүлсэн байна.	12
1.2.2. Торгуулийн орлогыг төлөвлөхдөө тоо хэмжээ болон суурь судалгаа, өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн төлөвлөөгүй байна.	13
1.2.3. Хүүгийн орлогыг ханшийн хэлбэлзэл, эдийн засгийн нөхцөл байдал зэргийг харгалзан тооцож төлөвлөөгүй байна.	15
1.2.4. Хүү, торгуулийн орлогоор санхүүжүүлэх зардлаас Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулах зардлыг урьдчилан тооцоолсон байна.	15
1.2.5. Орон нутгийн түвшинд хүү, торгуулийн орлого өмнөх оны төлөвлөгөөнөөс давсан болон дутсан шалтгааныг үнэлж дүгнээгүй байна.	17
1.2.6. Орлогын эх үүсвэрийг хуулийн хүрээнд тооцоолсон байна.	17
1.3. Хүү, торгуулийн орлого холбогдох хуульд заасан шаардлагад нийцсэн байна.	18
1.3.1. Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлтийн хууль, эрх зүйн орчин нь бодит хэрэгцээ шаардлагыг хангасан харилцан уялдаатай байна.	18
1.3.2. Хүү бодох аргачлал, хугацаа, хүүгийн хувь хэмжээ тодорхой хуульчилсан байна.	20
1.3.3. Хуулийн зарим тодорхойгүй заалтууд орлого бүрдүүлэлтэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.	21
1.3.4. Торгуулийн хэмжээ нь үйлдсэн зөрчилтэй нь нийцэж байгаа эсэхийг орон нутгийн түвшинд дүгнэх боломжгүй байна.	21
1.3.5. Хууль хэрэглээ нь бүх нийтэд адил тэгш үйлчилж чадаж байгаа эсэхийг дүгнэх боломжгүй байна.	22
1.3.6. Орлого бүрдүүлэлтийн эрхзүйн үндэслэлд шинэчлэл, сайжруулалт хийх хэрэгцээ шаардлага байна.	22
1.3.7. Хүү, торгуулийн орлого нь иргэний өмчийн халдашгүй байдалтай зөрчилдсөн асуудал байхгүй байна.	24
БҮЛЭГ 2. Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлтийг хууль, журамд нийцүүлэн төвлөрүүлсэн байна.	25
2.1. Ногдуулсан хүү, торгуулийн орлогыг төсөвт 98.3 хувьтай төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлт хангагдсан байна.	25
2.1.1. Хууль, журмын дагуу тогтоосон торгуулийн орлогоос 2023 онд 98 хувийг, 2024 онд 98.6 хувийг төсөвт төвлөрүүлсэн байна.	25
2.1.2. Торгуулийг эрх бүхий байгууллага, албан тушаалтан тавьсан байна.	28



2.1.3.	Орлого бүрдүүлэлтийг санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд үнэн зөв тусгасан байна.	30
2.1.4.	Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлт нь төсвийн орлогын бусад эх үүсвэрт нөлөөлж байна.	31
2.2.	Торгуулиас бүрдсэн орлогыг хууль, журмын дагуу хуваарилсан ч гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хуваарилсан зардал хуульд заасан хувь хэмжээнд нийцэхгүй байна.	33
2.2.1.	Төсвийг хуваарилах эрх бүхий байгууллага бүрэн эрхээ хэрэгжүүлсэн байна.	33
2.2.2.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан хуваарилсан зардал хуульд заасан хувь хэмжээнд нийцэхгүй байна.	34
2.2.3.	Торгуулийн орлогын тодорхой хувийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан хуваарилсан байна.	36
2.2.4.	Орлогын төлөвлөгөө биелүүлсэн байдал, төвлөрүүлсэн орлогын хэмжээгээр албан хаагчдын ажил дүгнэх үзүүлэлтийг харгалзан үзээгүй байна.	37
БҮЛЭГ 3.	Торгуулийн орлогоос хуулийн хүрээнд хуваарилсан зардлын гүйцэтгэл зохих үр дүнтэй байна.	38
3.1.	Хүүгийн орлого, торгуулийн орлогоос гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хуваарилсан зардлыг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулсан байна.	38
3.1.1.	Хүүгийн орлого, торгуулийн орлогоос гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хуваарилсан зардлыг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулсан байна.	38
3.1.2.	Хүү, торгуулийн орлогыг эдийн засгийн ангилал хооронд шилжүүлэн, зарцуулаагүй байна.	40
3.1.3.	Хүү, торгуулийн орлогоор санхүүжүүлсэн арга хэмжээ нь олон нийтэд хүртээмжтэй байна.	42
3.1.4.	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил нь нийгэм, эдийн засагт зохих эерэг нөлөө үзүүлж байна.	42
3.2.	Хүү, торгуулийн орлогоос хуваарилсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын гүйцэтгэлийг ил тод мэдээлж байна.	44
3.2.1.	Хүү, торгуулийн орлогоос хуваарилсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын гүйцэтгэлийг шилэн дансны цахим хуудсаар мэдээлсэн байна.	44
3.2.2.	Аймаг, сумдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс үйл ажиллагааны тайлангаа олон нийтэд мэдээлсэн байна.	44
3.2.3.	Иргэд, төрийн бус байгууллага, хяналтын зөвлөл зэрэг оролцогч талууд хүү, торгуулийн орлогын зарцуулалтын ил тод байдалд үнэлгээ өгөөгүй, санал хүргүүлээгүй байна.	45
БҮЛЭГ 4.	Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байгаагаас үр дүнг үнэлэх боломжгүй байна.	46
4.1.	Хүү, торгуулийн орлогын бүртгэл мэдээллийн нэгдсэн сан байхгүй байна.	46
4.1.1.	Байгууллага хооронд мэдээллийн нэгдсэн сан байхгүй байна.	46
4.1.2.	Торгуулийн төлбөрийн системийн хэрэгжилт Цагдаагийн газар, Татварын газрын хувьд зохих түвшинд хангагдаж байна.	47
4.1.3.	Зарим байгууллагын хяналтын систем нь орлого бүрдүүлэлтийн үр дүнд нөлөөлж байна.	48
4.2.	Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад эрх бүхий байгууллагуудаас тавих хяналт хангалтгүй байна.	49
4.2.1.	Хугацаа хэтэрсэн, насжилт өндөртэй хүү, торгуулийн орлогыг барагдуулах ажлыг зохион байгуулж, дараагийн шатны арга хэмжээг авч ажилласан байна.	49
4.2.2.	Төрийн аудитын газраас Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын зарцуулалтад хяналт хэрэгжүүлсэн, бусад эрх бүхий байгууллагын зүгээс хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт хэрэгжүүлээгүй байна.	50
4.2.3.	Орлого төвлөрүүлэгч байгууллагууд нь торгуулийн орлогод дотоод хяналт хэрэгжүүлээгүй байна.	51
4.2.4.	Хөндлөнгийн байгууллагаас хяналт хэрэгжүүлээгүй байна.	52



ДҮГНЭЛТ	53
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ	54
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН ИРҮҮЛСЭН САНАЛД ӨГӨХ ТАЙЛБАР	58
ЗӨВЛӨМЖ.....	59



ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

УВА	Увс аймаг
ШТА	Шууд тайлагнах аудит
ГА	Гүйцэтгэлийн аудит
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ШШГГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
ОНТҮГ	Орон нутгийн төсөвт үйлдвэрийн газар
ББЭХС	Баруун бүсийн эрчим хүчний систем
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
АЗЗА	Авто зам, засвар арчлалт
ЦТС	Цахилгаан түгээх сүлжээ
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ГХУСАЗСЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ТББ	Төрийн бус байгууллага
ОУБ	Олон улсын байгууллага

**ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ**

Хүснэгт 1. Төсвийн орлогын ангилал	8
Хүснэгт 2. Байгууллага, аж ахуйн нэгжүүдийн төвлөрсөн хүүгийн орлого	9
Хүснэгт 3. Аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор баталсан торгуулийн орлого	11
Хүснэгт 4. Аймаг, сумдын торгуулийн орлогын гүйцэтгэл	12
Хүснэгт 5. ИТХ-ын баталсан хүү, торгуулийн орлого, төвлөрүүлсэн орлого	14
Хүснэгт 6. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын тоо, төлөвлөсөн санхүүжилт	16
Хүснэгт 7. Хүү, торгуулийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл	18
Хүснэгт 8. Тайлант онд илрүүлсэн зөрчил, түүнд ногдуулсан торгуулийн дүн	25
Хүснэгт 9. Торгуулийн төвлөрсөн орлогын эзлэх хувь	26
Хүснэгт 10. Торгох эрх бүхий албан тушаалтныг байгууллагаар задлан харуулбал:	29
Хүснэгт 11. Аймаг, сумдын торгуулийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл 2023, 2024 оны хувьд дараах байдалтай байна. Үүнд:	30
Хүснэгт 12. Төсвийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэл орлогын нэр төрлөөр	31
Хүснэгт 13. 2024 оны сумдын ИТХ-аар баталсан төсвийн орлогын гүйцэтгэлд хүү, торгуулийн орлогын эзлэх хувь	32
Хүснэгт 14. 2024 онд төвлөрсөн торгуулийн орлого болон 2025 оны батлагдсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардал	35
Хүснэгт 15. Аймаг, сумдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга, хэмжээний зардлын хуваарилалт	36
Хүснэгт 16. Хүүгийн орлогын зарцуулалт	38
Хүснэгт 17. Аймаг, сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл	39
Хүснэгт 18. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын төлөвлөгөө, зарцуулалт	41
Хүснэгт 19. Торгуулийн орлогын нэгтгэл	49

ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Татварын бус орлогод эзлэх хүү, торгуулийн хувь	13
Зураг 2. Торгуулийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл	17
Зураг 3. Ногдуулсан торгуулийн орлого, төвлөрүүлсэн орлого	27
Зураг 4. Эрх бүхий албан тушаалтан боловсрол түвшнээр	28
Зураг 5. Эрх бүхий албан тушаалтан ажилласан жилээр	28
Зураг 6. Хүү, торгуулийн орлогын эзлэх хувь	32
Зураг 7. Төвлөрүүлсэн орлого, төсвийн ангиллаар, хувиар	50

**Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх:**

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2024 оны А/108 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө, Увс аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан дүнг Нийслэл дэх Төрийн аудитын газарт хүргүүлж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн. Уг зорилтын хүрээнд дараах дэд асуудлуудад аудитыг чиглүүлэн хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- *Хүү, торгуулийн орлогын төлөвлөлт нь хэрэгцээ шаардлагад нийцсэн эсэх;*
- *Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлтийг хууль, журамд нийцүүлэн төвлөрүүлсэн эсэх;*
- *Хүү, торгуулийн орлогын зарцуулалт үр дүнтэй эсэх;*
- *Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналт үр дүнтэй хэрэгжсэн эсэх.*

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад хүү, торгуулийн орлого төлөвлөх, бүрдүүлэх, зарцуулах, хяналт хэрэгжүүлдэг төрийн байгууллагуудын холбогдох чиг үүргийн хэрэгжилт, 2023, 2024 онд хүү, торгуулийн орлогыг бүрдүүлсэн байдал, зарцуулалт, хяналт хэрэгжүүлэхтэй холбоотой тайлан мэдээ, дансны хуулга, бусад нотлох баримт, материалыг хамруулсан.

Аудитын хүрээнд 30 төсвийн шууд захирагч, 9 төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 4 арилжааны банканд албан бичиг хүргүүлэн холбогдох мэдээлэл, судалгааг авч нэгтгэсэн.

Аудитын арга зүй:

Аудитад гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000-д нийцүүлэн боловсруулсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, Монгол улсын Ерөнхий аудиторовын А/106 дугаар тушаалаар баталсан 2020 оны "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, судалгааны арга зүйг ашигласан.

**Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн, хугацаа**

Гүйцэтгэлийн аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан хэрэгжүүлэн, ахлах аудитор Т.Намжил, Ч.Мөнхтогтох, аудитор Т.Амармэнд, Б.Нямбуу, Т.Ариунсайхан, Л.Шагдарсүрэн нар 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс 7 дугаар сарын 21-ний өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.

Аудитын дүн

Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хийсэн аудитаар 2 зөвлөмж өгч, Үндэсний аудитын газарт 2 санал хүргүүлсэн болно.

Увс аймаг дахь Төрийн аудитын газраас өмнөх онуудад гүйцэтгэсэн аудитаар илрүүлсэн аймаг, сумдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын зарцуулалттай холбоотой зөрчлүүдийг аудитын тайланд давхардуулан тусгаагүй болно.

Ерөнхий мэдээлэл

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7.2, 23.9.2 дахь хэсэгт "... хүү, торгуулийн орлого" нь аймаг, нийслэл болон улсын зэрэглэлтэй хот, сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсвийн татварын бус орлогод хамаарахаар зохицуулагдсан.

Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалаар баталсан төсвийн орлогын эдийн засгийн ангиллын дагуу татварын бус орлогын нийтлэг татварын бус орлогод хамаарч "хүү, торгуулийн орлого" гэсэн ангиллаар орон нутгийн төсвийн гүйцэтгэлд тайлагнагдаж байна. Төсвийн орлогын ангиллын Улсын хэмжээний дүн мэдээг 2023, 2024 оноор харьцуулан харуулбал:

Хүснэгт 1. Төсвийн орлогын ангилал*/сая төгрөгөөр/*

Үзүүлэлт	Улсын төсөвт		Орон нутгийн төсөвт	
	2023	2024	2023	2024
Татварын орлого	21,484,155.0	27,377,483.8	3,818,308.3	5,665,105.7
Татварын бус орлого	1,451,747.0	1,769,842.6	1,073,016.8	1,468,172.9
Хүү, торгуулийн орлого	-	-	142,782.1	220,063.9

Эх сурвалж: <https://www.1212.mn>

Хүснэгтээс харахад татварын бус орлогын 13-15 хувийг хүү, торгуулийн орлого эзэлж байна. Дээрх орлого 2023 онд 142,781.1 сая төгрөг байсан бол 2024 онд 220,063.9 сая төгрөг болж 35.1 хувиар өссөн байна.

Сангийн яамнаас ирүүлсэн мэдээллээр Увс аймгийн хэмжээнд 2023, 2024 онд 3,167.9 сая төгрөгийн хүү, торгуулийн орлогыг бүрдүүлсэн нь 100.0 хувь торгуулийн орлого байна.

**БҮЛЭГ 1**

Торгуулийн орлогыг хуулийн хүрээнд төлөвлөсөн ч өмнөх оны гүйцэтгэлд үндэслээгүй, хүүгийн орлогыг төлөвлөөгүй байна.

1.1. Хүүгийн орлогыг төлөвлөөгүй, торгуулийн орлогын төлөвлөлт нь бодит хэрэгцээ шаардлагад нийцсэн байна.

1.1.1. Хүүгийн орлогыг төлөвлөөгүй байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9 дэх заалтад "төсвийн орлого" гэж хууль тогтоомжийн дагуу улсын болон орон нутгийн төсөв бүрдүүлэх орлого, төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг", 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт "Төсвийн орлого нь татварын орлого, татварын бус орлогоос бүрдэнэ" гэж заажээ.

Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэгт "Цар тахлын үед банкны хугацаагүй хадгаламж, харилцах дансанд хүү тооцохгүй, тусгай нөхцөлтэй хадгаламжид энгийн хадгаламжийн хүү тооцох бөгөөд Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1-д заасны дагуу Монголбанкнаас зөвшөөрөл олгосон болон 4.4-т зааснаас бусад тохиолдолд иргэн, хуулийн этгээд хоорондын мөнгөн төлбөрийн үүрэг, гүйлгээг гадаад валютаар гүйцэтгэхийг хориглоно" гэж заасан байна.

Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт "Энэ хууль 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал үйлчилнэ" гэж заасан байна. Монгол банкны ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайдын хамтарсан 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А-7/8/4 дүгээр "Харилцах дансны үлдэгдэлд тооцох хүүгийн хувь хэмжээг тогтоох тухай" тушаалын 1-д Харилцах дансны үлдэгдэлд тооцох хүүгийн хэмжээг жилийн 3 хүртэл хувиар тогтоосугай" гэж заасан байна.

Аймгийн хэмжээнд дараах байгууллага, аж ахуйн нэгжүүд 2023, 2024 онд хүүгийн орлого төвлөрүүлсэн байна. Үүнд:

Хүснэгт 2. Байгууллага, аж ахуйн нэгжүүдийн төвлөрсөн хүүгийн орлого

/мянган төгрөгөөр/

Д/Д	Байгууллагын нэр	Үүнээс				Нийт дүн	
		2023 он		2024 он			
		Төлөвлөлт	Гүйцэтгэл	Төлөвлөлт	Гүйцэтгэл	Төлөвлөлт	Гүйцэтгэл
1	Увс аймгийн Нийгмийн даатгалын газар		55,839.5		53,657.9		109,497.4
2	Увс аймаг дахь ШШГГ				902.6		902.6



3	Автотээврийн төв	-	66.5	-	365.6	-	432.1
4	Улаангом тохижилт үйлчилгээ ОНТҮГ	80.0	67.8	119.1	182.9	199.1	250.7
5	ББЭХС ТӨХК	-	10,327.1	-	76,883.6	-	87,210.8
6	АЗЗА ТӨХК				5.0		5.0
7	Увс ЦТС ХХК				94.9		94.9
8	Чандмань-Увс ХХК				239.8		239.8
9	"Улаангомьын дулааны 2-р станц" ТӨХК		1,597.3		1,423.8		3,025.3
	Нийт	80.0	67,898.2	119.1	133,756.1	199.1	201,658.5

Эх сурвалж: Аудитын хүрээнд авсан нэгтгэл судалгаа

Судалгаанаас үзэхэд Улаангом тохижилт үйлчилгээ ОНТҮГ 2023 онд 80.0 мянга, 2024 онд 119.1 мянга, нийт 199.1 мянган төгрөгийн хүүгийн орлогыг бизнес төлөвлөгөөндөө тусгасан байна. Бусад байгууллага, аж ахуйн нэгжүүдийн хувьд хүүгийн орлогыг төлөвлөөгүй байна.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт "Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг найдвартай, үр өгөөжтэй, хариуцлагатай, ил тод, хараат бус байх зарчмыг баримтлан дараах санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулж болно", 13.1.4 дэх заалтад "Банкны тухай хуулийн 3.1.20-д заасан арилжааны банк /цаашид "арилжааны банк" гэх/-нд байршуулах мөнгөн хадгаламж", Засгийн газрын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 254 дүгээр тогтоолоор баталсан "Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах журам"-ын 6.1-д "Нийгмийн даатгалын ерөнхий газар сангийн чөлөөт үлдэгдлийг энэ журмын 2.1.4-т заасны дагуу арилжааны банканд байршуулах ажлыг зохион байгуулна" гэж заасан байна.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэгт "Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байгууллага нь нийгмийн даатгалын сан тус бүрийн орлогын зарцуулагдаагүй үлдэгдлийг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын холбогдох дансанд сар бүр төвлөрүүлнэ" гэж заасны дагуу төвлөрүүлдэг бөгөөд аймгийн Нийгмийн даатгалын газар 2023, 2024 онд хүүгийн орлогыг төлөвлөөгүй байна.

Цаашид хүүгийн орлогыг төлөвлөх, байгууллага, аж ахуйн нэгжийн чөлөөт үлдэгдэлд хүү тооцуулах замаар орлогыг бүрэн төвлөрүүлэхэд анхаарч ажиллахыг зөвлөлөө.

1.1.2. Торгуулийн орлогыг төлөвлөх бодит хэрэгцээ шаардлагатай байна.

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт "Төсвийн орлого нь татварын орлого, татварын бус орлогоос бүрдэнэ", 23.3 дахь хэсэгт "Татварын бус орлого нь төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн болон орон нутгийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг, төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр,



төрийн болон орон нутгийн өмчийг түрээсэлсний орлого, **торгуулийн орлого**, төсвийн байгууллагын туслах үйл ажиллагааны орлого, Засгийн газрын зээллэг, тусламж болон хууль тогтоомжийн дагуу төсөвт төвлөрүүлэх бусад орлогоос бүрдэнэ”, 23.7 дах хэсэгт “Аймаг, нийслэл болон улсын зэрэглэлтэй хотын төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ”, 23.7.2 дах заалтад “Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого”, 23.9 дэх хэсэгт “Сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ”, 23.9.2 дахь заалтад “Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого” гэж заасан байна.

Мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.29 дэх заалтад “Орон нутгийн төсвийн суурь орлого” гэж тухайн шатны төсөвт орох татварыг доод хувь, хэмжээгээр тооцсон орлого болон татварын бус орлогын нийлбэрийг”, 58 дугаар зүйлийн 58.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 4.1.30-д заасан орон нутгийн төсвийн суурь зарлагыг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ”, 58.1.1 дэх заалтад “Аймаг, сум, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгон, нийслэл, дүүрэг, улсын зэрэглэлтэй хотын татварын болон татварын бус орлого” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн дээрх зохицуулалтаас харахад аймаг, сумдын хувьд торгуулийн орлогыг төлөвлөх шаардлагатай байна.

Увс аймгийн хувьд 2023 онд торгуулийн орлогыг сумдаар нь салгаж төлөвлөөгүй, аймгийн хэмжээнд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар нийт 850,000.0 мянган төгрөгөөр, 2024 онд торгуулийн орлогыг аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар нийт 1,659,500.0 мянган төгрөгөөр тооцож төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор баталсан торгуулийн орлого

/мянган төгрөгөөр/

Д/д	Сумын нэр	Аймаг, сумын ИТХ-ын тогтоолын огноо, дугаар	2023 он	Аймаг, сумын ИТХ-ын тогтоолын огноо, дугаар	2024 он
1	Баруунтуруун	2023.07.25 №8/01	-	2024.09.27 №13	20,000.0
2	Бөхмөрөн	2023.07.27 №11/07	-	2024.09.24 -16/03	20,000.0
3	Давст	2023.07.24 №14/01	-	2024.09.25 18/01	10,000.0
4	Завхан	2023.07.25 №11/01	-	2024.11.05 №2/01	20,000.0
5	Зүүнговь	2023.07.27 №12/01	-	2024.09.25 №18/02	20,000.0
6	Зүүнхангай	2023.07.25 №13/01	-	2024.10.08 №18/01	20,000.0
7	Малчин	2023.07.25 №A/05	-	2024.09.25 №A/11	45,000.0
8	Наранбулаг	2023.07.22 №15/01	-	2024.10.15 №22/01	20,000.0
9	Өлгий	2023.07.28 №11/01	-	2024.09.23 №16/01	20,000.0
10	Өмнөговь	2023.07.28 №12/01	-	2024.09.27 №18/01	20,000.0
11	Өндөрхангай	2023.07.27 №15/01	-	2024.09.27 №22/01	20,000.0
12	Сагил	2023.07.28 №11/03	-	2024.11.13 №2/01	15,000.0
13	Тариалан	2023.07.25 №13/01	-	2024.09.30 №17/01	105,000.0
14	Түргэн	2023.07.28 №12/02	-	2024.09.20 №18/04	45,000.0



15	Тэс	2023.08.04 №11/01	-	2024.09.20 №16/01	20,000.0
16	Ховд	2023.07.25 №13/01	-	2024.09.24 №18/03	24,500.0
17	Хяргас	2023.07.27 №11/01	-	2024.09.23 №18/01	20,000.0
18	Цагаанхайрхан	2023.07.28 №13/01	-	2024.09.20 №18/01	15,000.0
19	Улаангом	2023.07.27 №15/04	-	2024.09.24 №22/04	130,000.0
20	Аймгийн ИТХ	2023.07.21 №14/01	850,000.0	2024.09.18 №21/01	1,050,000.0
Нийт дүн			850,000.0		1,659,500.0

Эх сурвалж: 2023, 2024 оны аймаг, сумын ИТХ-ын тогтоол

Мөн Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт “Нийгмийн даатгалын сангийн орлого дараах эх үүсвэрээс бүрдэнэ”, 11.1.5 дахь заалтад “Нийгмийн даатгалын шимтгэл төлөх хугацаа хэтрүүлсэн, цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын хэмжээг бууруулсан болон нуусан орлогод тооцсон алданги, **торгууль**” гэж заасны дагуу торгуулийн орлогыг төлөвлөхөөр байна.

Бусад торгуулийн орлого төвлөрүүлдэг салбар, байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа хууль, тогтоомжид торгуулийн орлогыг төлөвлөх талаар нарийвчлан зохицуулалт байхгүй байна.

1.2. Хүү, торгуулийн орлогыг гүйцэтгэлд үндэслэн төлөвлөөгүй байна.

1.2.1. Торгуулийн орлогын төлөвлөгөөг 2022-2024 онд давуулан биелүүлсэн байна.

Торгуулийн орлогыг 2022, 2023 онд сумдад төлөвлөөгүй, аймгийн хэмжээнд нэгтгэн төлөвлөж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталж байжээ. Харин 2024 онд аймаг, сумдын төсөвт тодотгол хийхдээ торгуулийн орлогын төлөвлөгөөг тусган аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан байна.

Аймаг, сумдын торгуулийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг 2022-2024 оноор харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 4. Аймаг, сумдын торгуулийн орлогын гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Он	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлтийн хувь
Аймаг	2022	800,000.0	1,480,900.0	680,900.0	185.1
	2023	850,000.0	1,238,800.0	388,800.0	145.7
	2024	1,050,000.0	1,311,372.1	261,372.1	124.9
Сум	2022	0.0	0.0	0.0	
	2023	0.0	0.0	0.0	
	2024	609,500.0	618,349.3	8,849.3	101.4

Эх сурвалж: Аймаг, сумын төсвийн захирагчийн санхүүгийн тайлан, ИТХ-ын тогтоол

Аймгийн торгуулийн орлогын төлөвлөгөөг 2022 онд 85.1 хувиар, 2023 онд 45.7 хувиар, 2024 онд 24.9 хувиар, сумдын 2024 оны торгуулийн орлогын төлөвлөгөө 1.4 хувиар тус тус давуулан биелүүлсэн байна.



1.2.2. Торгуулийн орлогыг төлөвлөхдөө тоо хэмжээ болон суурь судалгаа, өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн төлөвлөөгүй байна.

Төсвийн орлого нь татварын болон татварын бус орлогоос бүрдэх бөгөөд хүү, торгуулийн орлого нь татварын бус орлогыг бүрдүүлэхэд гол хүчин зүйл болж байна. Аймгийн ИТХ-ын 2023, 2024 оны төсвийг тодотгон батлахдаа татварын бус орлогод хүү, торгуулийн орлогыг дараах байдалтай төлөвлөсөн байна.

Зураг 1. Татварын бус орлогод эзлэх хүү, торгуулийн хувь



Эх сурвалж: Аймгийн ИТХ-ын тогтоол

Торгуулийн орлого төсөвт төвлөрүүлдэг байгууллагуудын хувьд тайлант онд хэчнээн зөрчил илрүүлэн торгохыг урьдчилан тооцоолох боломжгүй тул торгуулийн орлогыг байгууллагын түвшинд төлөвлөдөггүй байна. Харин аймаг, сумдын төсвийн төслийг боловсруулахдаа төсөвт төвлөрүүлэх хүү, торгуулийн орлогыг төлөвлөн баталж байна.

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.9 дэх хэсэгт “Сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ”, 23.9.2 дахь заалтад “Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого” гэж заасан байна. Гэтэл 2023 онд аймаг, сумдын хүү, торгуулийн орлогыг аймгийн хэмжээнд нэгтгэн төлөвлөж, сумдын хүү, торгуулиас орсон орлогыг аймгийн ерөнхий орлогод сар бүр төвлөрүүлж байсан байна.

Увс аймгийн ИТХ-ын 2023 оны төсвийн тодотгол баталсан 14/01 дүгээр тогтоолоор хүү, торгуулийн орлогыг 850,000.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөжээ.

Харин 2024 оны 09 дүгээр сараас эхлэн аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор хүү, торгуулийн орлогыг дараах байдлаар төлөвлөн баталжээ. Үүнд:



Хүснэгт 5. ИТХ-ын баталсан хүү, торгуулийн орлого, төвлөрүүлсэн орлого

/мянган төгрөгөөр/

№	Нэрс	ИТХ-ын тогтоолын огноо, дугаар	2024 оны төлөвлөгөө /тодотголоор/	2024 оны гүйцэтгэл	2025 оны төлөвлөгөө
1	Баруунтуруун сум	2024.09.27 №13	20,000.0	4,361.5	20,000.0
2	Бөхмөрөн сум	2024.09.24 -16/03	20,000.0	2,712.5	20,000.0
3	Давст сум	2024.09.25 18/01	10,000.0	-	10,000.0
4	Завхан сум	2024.11.05 №2/01	20,000.0	2,190.6	20,000.0
5	Зүүнговь сум	2024.09.25 №18/02	20,000.0	5,399.0	20,000.0
6	Зүүнхангай сум	2024.10.08 №18/01	20,000.0	5,083.5	20,000.0
7	Наранбулаг сум	2024.10.15 №22/01	20,000.0	9,384.5	20,000.0
8	Өлгий сум	2024.09.23 №16/01	20,000.0	2,667.5	20,000.0
9	Сагил сум	2024.11.13 №2/01	15,000.0	4,585.0	15,000.0
10	Тэс сум	2024.09.20 №16/01	20,000.0	2,175.0	20,000.0
11	Хяргас сум	2024.09.23 №18/01	20,000.0	5,082.3	20,000.0
12	Цагаанхайрхан сум	2024.09.20 №18/01	15,000.0	2,270.0	15,000.0
13	Малчин сум	2024.09.25 №A/11	45,000.0	37,899.0	45,000.0
14	Өндөрхангай сум	2024.09.27 №22/01	20,000.0	19,153.0	20,000.0
15	Түргэн сум	2024.09.20 №18/04	45,000.0	50,996.7	45,000.0
16	Тариалан сум	2024.09.30 №17/01	105,000.0	118,422.5	128,000.0
17	Ховд сум	2024.09.24 №18/03	24,500.0	49,144.0	20,000.0
18	Өмнөговь сум	2024.09.27 №18/01	20,000.0	10,720.5	30,000.0
19	Улаангом сум	2024.09.24 №22/04	130,000.0	286,102.2	543,000.0
20	Аймгийн ИТХ	2024.09.18 №21/01	1,050,000.0	1,311,372.1	550,000.0
	Нийт		1,659,500.0	1,929,721.4	1,601,000.0

Эх сурвалж: Аймаг сумдын ИТХ-ын тогтоол, 2024 оны санхүүгийн тайлан

Хүү, торгуулийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл 2023 оны хувьд сумдаар байхгүй тул 2025 оны хүү, торгуулийн орлогын төлөвлөгөөг 2024 оны гүйцэтгэлд үндэслэн төлөвлөсөн эсэхийг харьцуулан үзэхэд дараах байдалтай байна.

- Өмнөх оны төлөвлөгөөний биелэлт хангалтгүй байхад өмнөх онтойгоо ижил түвшинд орлогыг төлөвлөсөн байна. Тухайлбал: 2025 оны хүү, торгуулийн орлогын төлөвлөлт 2024 онтойгоо ижил 15 сум байна. Үүнд: төлөвлөгөөгөө 113.3 хувьтай гүйцэтгэсэн 1 сум, 84.2-95.8 хувьтай гүйцэтгэсэн 2 сум, 11.0-46.9 хувьтай хэрэгжсэн 12 сум, орлого төвлөрүүлээгүй 1 сум байна.
- Төлөвлөгөө хангалттай биелсэн байхад 2025 оны төлөвлөлтийг өмнөх оноосоо бууруулан төлөвлөсөн байна. Тухайлбал: Аймаг болон Ховд сумын хүү, торгуулийн орлогын 2024 төлөвлөгөөний биелэлт 24.9-120.1 хувиар давж биелсэн байхад 2025 оны төлөвлөлтийг өмнөх оны төлөвлөлтөөс 18.4-47.6 хувиар бууруулан төлөвлөжээ.
- Төлөвлөгөөний биелэлт хангалтгүй байхад дараа оны төлөвлөлтийг нэмэгдүүлэн төлөвлөсөн байна. Өмнөговь сумын хувьд 2024 оны төлөвлөгөөг 53.6 хувьтай биелүүлсэн байхад 2025 оны төлөвлөлтийг өмнөх оны төлөвлөлтөөс 50.0 хувиар нэмэгдүүлэн төлөвлөжээ.
- Улаангом сумын хувьд 2024 оны төлөвлөгөөг 2.2 дахин давуулан биелүүлсэн хэдий ч 2025 оны төлөвлөлтийг хийхдээ 2024 оны гүйцэтгэлийг 189.8 хувиар нэмэгдүүлэн төлөвлөжээ.

Эдгээрээс үзэхэд төлөвлөлтийг хийхдээ суурь судалгаа, өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн бодитой төлөвлөлт хийгээгүй байна.

Цаашид торгуулийн орлогыг эх үүсвэрт суурилсан тооцоо, судалгаа, өмнөх оны гүйцэтгэлд үндэслэсэн бодитой төлөвлөхийг зөвлөмж болголоо.

**1.2.3. Хүүгийн орлогыг ханшийн хэлбэлзэл, эдийн засгийн нөхцөл байдал зэргийг харгалзан тооцож төлөвлөөгүй байна.**

Монгол банкны ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайдын хамтарсан 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А-7/8/4 дүгээр “Харилцах дансны үлдэгдэлд тооцох хүүгийн хувь хэмжээг тогтоох тухай” тушаалын 1-д Харилцах дансны үлдэгдэлд тооцох хүүгийн хэмжээг жилийн 3 хүртэл хувиар тогтоосугай” гэж заасан байна.

Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа арилжааны банкнуудын хувьд байгууллага, аж ахуйн нэгжүүдийн дансны чөлөөт үлдэгдэлд 2023, 2024 онд дараах хувь хэмжээгээр хүү тооцож олгожээ. Үүнд:

- ХААН банк: Нийгмийн даатгалын газарт 3 хувь, ББЭХС ТӨХК-д 0.8 хувь,
- Голомт банк: Нийгмийн даатгалын газарт 3 хувь, ББЭХС ТӨХК болон Улаангомын дулааны 2-р станц ТӨХК-д 2 хувь, Чандмань Увс ХХК-д 1.2 хувь,
- Хас банк: Нийгмийн даатгалын газарт 3 хувь, ББЭХС ТӨХК-д 0.8 хувь /2024 оны 12 сард 1.2 хувь/
- Төрийн банк: Нийгмийн даатгалын газарт 3 хувь, ББЭХС ТӨХК-д 1.2-2.4 хувь, ЦТС ХХК-д 1.2 хувь, Увс АЗЗА ТӨХК-д 1.2 хувь

Дээрх хүүгийн орлого төвлөрүүлж байгаа төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдээс ханшийн хэлбэлзэл, эдийн засгийн нөхцөл байдал зэргийг харгалзан хүүгийн орлогыг төлөвлөсөн байгууллага, аж ахуйн нэгж байхгүй байна.

1.2.4. Хүү, торгуулийн орлогоор санхүүжүүлэх зардлаас Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулах зардлыг урьдчилан тооцоолсон байна.

Хүүгийн орлого төвлөрүүлдэг төсвийн байгууллага, аж ахуйн нэгжүүд хүүгийн орлогоор санхүүжүүлэх зардлыг урьдчилан тооцоолдоггүй бөгөөд дансанд нь төвлөрч үйл ажиллагааны зардалд зарцуулагддаг байна.

Торгууль ногдуулдаг байгууллагын хувьд торгуулийн орлого нь Улс, орон нутгийн төсөвт төвлөрдөг бөгөөд торгуулийн орлогоор санхүүжүүлэх зардлыг урьдчилан тооцоолдоггүй байна.

Харин Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэгт “... зөрчилд оногдуулсан торгох шийтгэлийг биелүүлж, төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүнгийн 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг дүрс бичлэгийн техник, хэрэгсэл, зөрчил болон эрүүгийн хэрэг хянан шалгах байгууллагын мэдээллийн нэгдсэн системийг сайжруулах ажилд, 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бусад ажилд зориулан дараагийн жилийн төсөвт тусгаж, санхүүжүүлнэ” гэж заасан байна.

Мөн Хууль зүйн сайд, Сангийн сайдын хамтарсан 88/152 дугаар тушаалаар баталсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журам”-ын 3-д “Аймаг, нийслэлийн



санхүүгийн байгууллага дараа жилийн төсвийн төслийг боловсруулахдаа энэ журмын 2-д заасан улсын орлогод оруулсан орлого болон төсөвт тушаасан мөнгөний тухайн жилийн урьдчилсан гүйцэтгэлд үндэслэн түүний 40 хувьтай тэнцэх хэмжээний орлогыг тооцож төсвийн зарлагад тусгай зүйл болгон тусгаж төлөвлөнө” гэж заасны дагуу аймаг, сумдын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлахдаа санхүүжүүлэх зардлыг урьдчилан тооцоолсон байна.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор батлахдаа 22 арга хэмжээг нийт 60,000.0 мянган төгрөгөөр хэрэгжүүлэхээр, 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тодотгол хийж 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 02 дугаар тогтоолоор батлахдаа 26 арга хэмжээг нийт 97,300.0 мянган төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Сумдын хувьд сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс нь тухайн жилд гүйцэтгэх ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд зардал санхүүжүүлэх эх үүсвэрийг дараах байдлаар төлөвлөж тусгасан байна. Үүнд:

Хүснэгт 6. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын тоо, төлөвлөсөн санхүүжилт

Д/д	Сумын нэр	2023		2024	
		Төлөвлөсөн ажлын тоо	Төлөвлөсөн санхүүжилт	Төлөвлөсөн ажлын тоо	Төлөвлөсөн санхүүжилт
1	Баруунтуруун	16		19	
2	Бөхмөрөн	14	5,355.0	22	6,221.4
3	Давст	39	4,167.0	36	4,167.7
4	Завхан	18	4,736.0	11	3,936.0
5	Зүүнговь	28	4,160.0	28	4,160.0
6	Зүүнхангай	25	4,270.0	16	4,275.0
7	Малчин	17	1,500.0	17	1,500.0
8	Наранбулаг	13		19	4,296.8
9	Өлгий	25	3,710.0	22	3,912.0
10	Өмнөговь	13		21	10,000.0
11	Өндөрхангай	19	4,000.0	20	4,050.0
12	Сагил	10	4,849.0	15	3,702.0
13	Тариалан	7	1,680.0	10	4,300.0
14	Түргэн	15		16	3,300.0
15	Тэс	21		24	
16	Ховд	20	5,500.0	47	
17	Хяргас	18	3,400.0	28	4,160.0
18	Цагаанхайрхан	12		10	4,008.7
19	Улаангом	15	36,380.9	17	105,000.0
Нийт дүн		345		379	

/мянган төгрөгөөр/

Эх сурвалж: Сумдын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн гүйцэтгэлийн төлөвлөгөө

Дээрх судалгаанаас харахад 2023 онд Баруунтуруун, Наранбулаг, Түргэн, Тэс,



Өмнөговь, Цагаанхайрхан сумд, 2024 онд Баруунтуруун, Ховд, Тэс сумд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө батлахдаа санхүүжилтийг тусгаагүй байна.


Цаашид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс тухайн жилд гүйцэтгэх ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлахдаа санхүүжилтийг тооцон төлөвлөж байхыг зөвлөлөө.

1.2.5. Орон нутгийн түвшинд хүү, торгуулийн орлого өмнөх оны төлөвлөгөөнөөс давсан болон дутсан шалтгааныг үнэлж дүгнээгүй байна.

Хүүгийн орлого төвлөрүүлэгч байгууллага, аж ахуйн нэгжүүд өмнөх онуудад хүүгийн орлогыг төлөвлөж байгаагүй байна.

Орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн торгуулийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл 2022-2024 оны хувьд дараах байдалтай байна.

Зураг 2. Торгуулийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл



Эх сурвалж: Аймаг, сумдын ИТХ-ын тогтоол

Судалгаанаас харахад торгуулийн орлого 2022 онд 85.1 хувиар, 2023 онд 45.7 хувиар, 2024 онд 15.7 хувиар тус тус давж биелсэн нь төлөвлөлтийг бодитой хийгээгүйг харуулж байна. Тухайлбал: 2022 оны гүйцэтгэл 1,480,900.0 мянган төгрөг байхад 2023 оны төлөвлөгөөг 850,000.0 мянган төгрөгөөр төлөвлөсөн байна.

Энэ нь Орон нутгийн түвшинд торгуулийн орлого өмнөх оны төлөвлөгөөнөөс давсан болон дутсан шалтгааныг үнэлж дүгнэх шаардлагатай байгааг харуулж байна.

Цаашид Төсвийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэгт "Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөлд дараах тооцоог хавсаргана", 31.4.5 дахь заалтад "Төсвийн гүйцэтгэлийн дүн шинжилгээний тайлан болон тухайн жилийн төсвийн хүлээгдэж байгаа гүйцэтгэлийн урьдчилсан тооцоо" гэж заасны дагуу торгуулийн орлого өмнөх оны төлөвлөгөөнөөс давсан болон дутсан нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж байхыг зөвлөв.

1.2.6. Орлогын эх үүсвэрийг хуулийн хүрээнд тооцоолсон байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9 дэх заалтад "Төсвийн орлого" гэж хууль тогтоомжийн дагуу улсын болон орон нутгийн төсөв бүрдүүлэх орлого,



төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг”, 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэгт “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 14.2.1 дэх заалтад “Жилийн төсвийн хязгаарт багтаан төсвийн төслийг боловсруулах”, 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт “Төсвийн төслийг боловсруулахад Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шаардлагаас гадна дараах шаардлага тавигдана”, 27.1.4 дэх заалтад “Жилийн төсвийн хязгаарт үндэслэсэн байх” гэж заасан байна.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн төслийг бэлтгэн хүргэхдээ хүү, торгуулийн орлогыг 2023 онд 850,000.0 мянга, 2024 онд 1,659,500.0 мянган төгрөгөөр тусган хүргүүлсэн байна.

Хүснэгт 7. Хүү, торгуулийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2023 он		2024 он	
	Хүүгийн орлого	Торгуулийн орлого	Хүүгийн орлого	Торгуулийн орлого
Сангийн яамны хянасан дүн	326,339.2	800,000.0	0.0	800,000.0
Анх батлагдсан төлөвлөгөө	0.0	850,000.0	0.0	1,050,000.0
Тодотголоор батлагдсан төлөвлөгөө	0.0	850,000.0	0.0	1,659,500.0
Гүйцэтгэл	0.0	1,238,678.9	239.8	1,929,721.4

Эх сурвалж: Аймаг, сумын ИТХ-ын тогтоол, сангийн яамны хянасан дүн

Хүү, торгуулийн орлогыг төлөвлөхдөө Сангийн яамны хянасан дүнг харгалзан үзсэн байна.

Монгол Улсын төсөвт тодотгол хийгдсэнтэй холбогдуулан Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь хэсэгт “Засаг дарга, хот, тосгоны Захирагч дараах тохиолдолд тухайн жилийн төсвийн тодотголыг боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Зөвлөлд өргөн мэдүүлнэ”, 34.2.1 дэх хэсэгт “Дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон” гэж заасны дагуу 2024 онд орон нутгийн төсвийн нийт орлогыг аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор тодотгон батлахдаа хүү, торгуулийн орлогыг сумдад нийт 609,500.0 мянган төгрөгөөр баталсан байна.

1.3. Хүү, торгуулийн орлого холбогдох хуульд заасан шаардлагад нийцсэн байна.

1.3.1. Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлтийн хууль, эрх зүйн орчин нь бодит хэрэгцээ шаардлагыг хангасан харилцан уялдаатай байна.

Банкны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт “Банк Монгол Улсын болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн /цаашид "иргэн" гэх/, хуулийн этгээдийн мөнгөн хөрөнгийг тэдгээрийн хүсэлтийн дагуу гэрээний үндсэн дээр хадгалж, түүнд хүү төлж болно”, Монгол банкны ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны



дарга, Сангийн сайдын 2023 оны 01 дүгээр сарын 09 ний өдрийн хамтарсан А-7/08//04 дүгээр “Харилцах дансны үлдэгдэлд тооцох хүүгийн хувь хэмжээг тогтоох” тухай тушаалын 1-д “Харилцах дансны үлдэгдэлд тооцох хүүгийн хэмжээг жилийн 3 хүртэл хувиар тогтоосугай” гэж заасны дагуу төсөвт байгууллага, Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүд арилжааны банк дахь харилцах болон хугацаагүй хадгаламжийн дансанд хүү тооцуулах боломжтой байна.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт “Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг найдвартай, үр өгөөжтэй, хариуцлагатай, ил тод, хараат бус байх зарчмыг баримтлан дараах санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулж болно”, 13.1.4 дэх заалтад “Банкны тухай хуулийн 3.1.20-д заасан арилжааны банк /цаашид “арилжааны банк” гэх/-нд байршуулах мөнгөн хадгаламж”, Засгийн газрын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 254 дүгээр тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах журам”-ын 6.1-д “Нийгмийн даатгалын ерөнхий газар сангийн чөлөөт үлдэгдлийг энэ журмын 2.1.4-т заасны дагуу арилжааны банканд байршуулах ажлыг зохион байгуулна” гэж заасан байна.

Харин хүүгийн орлого төвлөрүүлдэг бусад төсөвт байгууллага, Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдэд мөрдөгдөж байгаа хууль, эрх зүйн орчинд нарийвчилсан зохицуулалт байхгүй байна.

Аймгийн хэмжээнд торгуулийн орлого бүрдүүлдэг 24 байгууллагын 315 торгох эрх бүхий албан тушаалтан байна. Тухайн байгууллагууд нь өөр өөрсдийн салбарын хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Зөрчлийн тухай хуульд заасны дагуу торгуулийн арга хэмжээ авч байна.

Зөрчлийн тухай хуулийн 1.1 дүгээр зүйлийн 1-д “Энэ хуулийн зорилго нь хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхгүйг зөрчилд тооцох, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах замаар шударга ёсны тогтолцоог бэхжүүлэхэд оршино” гэж заасан нь улсын хэмжээнд мөрдөгдөж байгаа бүхий л хуулийн хүрээнд шийтгэл ногдуулах арга хэмжээг нэгтгэн зохицуулж өгсөн байна. Өөрөөр хэлбэл, торгууль ногдуулах эрх бүхий байгууллагуудын торгуулийн хувь хэмжээг энэ хуулиар зохицуулсан байна.

Мөн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.2 дугаар зүйлийн 1-д “Зөрчил шалган шийдвэрлэх хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ”, 1.3 дугаар зүйлийн 1-д “Монгол Улсын нутаг дэвсгэрт зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа нь зөрчил хаана гарсныг үл харгалзан энэ хуулийн дагуу явагдана”, 1.8 дугаар зүйлийн 1-д “Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг уг зөрчил үйлдэгдсэн нутаг дэвсгэр, энэ хуульд заасан харьяаллын дагуу явуулна” 1.8 дугаар зүйлийн 6-д “Дараах эрх бүхий албан тушаалтан доор дурдсан харьяаллын дагуу зөрчлийг шалган шийдвэрлэнэ” гэж тус тус заасны дагуу Зөрчлийн тухай хуульд заасан зөрчлүүдийг шалган шийдвэрлэх ажиллагааг явуулж байна.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт “Нийгмийн даатгалын сангийн орлого дараах эх үүсвэрээс бүрдэнэ”, 11.1.5 дахь заалтад “Нийгмийн даатгалын шимтгэл төлөх хугацаа хэтрүүлсэн, цалин хөлс,



түүнтэй адилтгах орлогын хэмжээг бууруулсан болон нуусан орлогод тооцсон алданги, **торгууль**” гэж заасны дагуу торгуулийн орлогыг бүрдүүлэхээр байна.

Бусад торгуулийн орлого төвлөрүүлдэг салбар, байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа хууль тогтоомжид торгуулийн орлогыг бүрдүүлэх талаар нарийвчлан зохицуулалт байхгүй байна.

1.3.2. Хүү бодох аргачлал, хугацаа, хүүгийн хувь хэмжээ тодорхой хуульчилсан байна.

Банкны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт “Банк Монгол Улсын болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн /цаашид "иргэн" гэх/, хуулийн этгээдийн мөнгөн хөрөнгийг тэдгээрийн хүсэлтийн дагуу гэрээний үндсэн дээр хадгалж, түүнд хүү төлж болно”, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэгт “Банкны эрх хүлээн авагч дараах бүрэн эрхтэй”, 69.1.10 дахь заалтад “Хадгаламжийн хүүгийн хувь хэмжээг тухайн үеийн хадгаламжийн хүүгийн доод хувь хэмжээнээс багагүй байхаар өөрчлөн тогтоох” гэж заасан байна.

Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6 дахь хэсэгт “Банк, эрх бүхий хуулийн этгээд өөрийн бүтээгдэхүүн, үйлчилгээний шимтгэл, хураамжийн хувь, хэмжээг үндэслэлтэй тогтоох бөгөөд үүнд Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо хяналт тавина”, 6.7 дахь хэсэгт “Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо өөрийн хянан зохицуулах чиг үүргийн хүрээнд банк, эрх бүхий хуулийн этгээдээс тогтоосон бүтээгдэхүүн, үйлчилгээний шимтгэл, хураамжийн хувь, хэмжээг бууруулахыг санал болгох, саналыг хүлээж аваагүй тохиолдолд тухайн шимтгэл, хураамжийн хувь, хэмжээ тогтоосон шийдвэрийг хүчингүй болгох бөгөөд энэ тухайгаа нийтэд мэдээлэх эрхтэй байна” гэж заажээ.

Төв банкны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1-д “Монголбанк төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхдээ дараах арга, хэрэгслийг ашиглаж болно”, 1.3-д “Хүүгийн нэгдсэн бодлого явуулах” 14 дүгээр зүйлд “Монголбанк нь өөрийн зээл, үнэт цаасны хүү болон хямдруулалтын хувиар дамжуулан банкны хүүгийн нэгдсэн бодлого явуулна”, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн А-203 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлын журам”-аар хүү бодох аргачлалыг тодорхой тусгаж өгсөн байна.

Мөн Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Харилцах дансны үлдэгдэлд тооцох хүүгийн хэмжээг эдийн засгийн нөхцөл байдлыг харгалзан Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран тогтооно” гэж заасны дагуу Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайдын 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн хамтарсан А-7/08//04 дүгээр “Харилцах дансны үлдэгдэлд тооцох хүүгийн хувь хэмжээг тогтоох”



тухай тушаалын 1-д Харилцах дансны үлдэгдэлд тооцох хүүгийн хэмжээг жилийн 3 хүртэл хувиар тогтоосугай” гэж заажээ.

1.3.3. Хуулийн зарим тодорхойгүй заалтууд орлого бүрдүүлэлтэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.

Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Захиргааны ерөнхий хуулийн зарим тодорхойгүй заалтууд орлого бүрдүүлэлтэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна. Тухайлбал; Зөрчлийн тухай хуулийн 7.11 дүгээр зүйлийн 7.11.3-т “Үнэт металл, эрдэнийн чулууны сорьц, чанарыг тогтоолгох, эсхүл бүртгүүлэх журам зөрчсөн бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж заасан нь Сорьцын хяналтын улсын байцаагчийн шийдвэрлэх хэргийн харьяалалд хамаарахаар байхад Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.42-т энэхүү зөрчлийг геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч шалгах шийдвэрлэхээр заасан нь Үнэт металл, эрдэнийн чулууны сорьц, чанарыг тогтоолгох, эсхүл бүртгүүлэх журам зөрчсөн зөрчилд Сорьцын хяналтын улсын байцаагч торгуулийн арга хэмжээ авах боломжгүй нөхцөл байдлыг үүсгэж байна.

Захиргааны ерөнхий хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1 дэх хэсэгт “Захиргааны шийдвэрийг дараах байгууллага гүйцэтгэнэ”, 84.1.1 дэх заалтад “Захиргааны актыг батлан гаргасан захиргааны байгууллага”, 85 дугаар зүйлийн 85.2 дахь хэсэгт “Захиргааны шийдвэрээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй этгээдэд захиргааны байгууллага хуульд заасан журмын дагуу албадлага хэрэглэнэ” гэж заасан боловч захиргааны акт гаргасан торгох эрх бүхий албан тушаалтан ямар журмаар гаргасан торгуулийн акт барагдуулах, захиргааны шийдвэр гүйцэтгэх албадлагын арга хэмжээг явуулах талаар нарийвчилсан зохицуулалт байхгүйгээс хуулийн хэрэгжилт хангагдахгүй байх эрсдэл үүсгэж байна. Энэ нь торгуулийн төлбөр барагдахгүй байх нэг шалтгаан болж байна.

1.3.4. Торгуулийн хэмжээ нь үйлдсэн зөрчилтэй нь нийцэж байгаа эсэхийг орон нутгийн түвшинд дүгнэх боломжгүй байна.

Зөрчлийн тухай хуулийн 1.2 дугаар зүйлийн 2-т “Зөрчил, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээний төрөл, хэмжээг энэ хуулиар тогтооно”, 1.3 дугаар зүйлийн 1-д “Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээний төрөл, хэмжээ нь зөрчил үйлдэгдсэн нөхцөл байдал, зөрчлийн шинж, хохирлын хэр хэмжээнд тохирсон байна”, 1.4 дүгээр зүйлийн 3-д “Зөрчилд тооцох, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээний төрөл, хэмжээг тухайн зөрчил үйлдэх үед дагаж мөрдөж байсан хуулийн дагуу шийдвэрлэнэ”, 2.1 дүгээр зүйлийн 1-д “Хууль, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн, энэ хуульд шийтгэл оногдуулахаар заасан үйлдэл, эс үйлдэхгүйг зөрчил гэнэ”, 2-т “Хүн, хуулийн этгээд нь хууль, захиргааны хэм хэмжээний актыг биелүүлэх боломжтой байсан боловч түүнийг биелүүлэх зохих арга хэмжээг хэрэгжүүлээгүй бол зөрчил үйлдсэнд тооцно”,



2.2 дугаар зүйлийн 1-д “Зөрчлийг хамтран үйлдсэн хүн, хуулийн этгээд тус бүрд шийтгэл оногдуулна” гэж заажээ.

Торгууль ногдуулах эрх бүхий албан тушаалтан зөрчил үйлдэгдсэн нөхцөл байдал, зөрчлийн шинж, хохирлын хэр хэмжээг тодорхойлж, хуульд заасан хувь хэмжээгээр торгууль ногдуулж байна.

Торгуулийн хэмжээ нь үйлдсэн зөрчилтэй нь нийцэж байгаа эсэхийг орон нутгийн түвшинд дүгнэх боломжгүй байна.

1.3.5. Хууль хэрэглээ нь бүх нийтэд адил тэгш үйлчилж чадаж байгаа эсэхийг дүгнэх боломжгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” гэж заасны дагуу Монгол Улсын хэмжээнд хэрэгжиж байгаа бүх хууль, тогтоомжуудад шударга ёс, эрх тэгш байдлын зарчмыг тусгаж өгсөн байдаг.

Сүүлийн жилүүдэд хууль сахиулах байгууллагын үйл ажиллагааг цахимжуулах, ил тод болгох, иргэдийн хяналт, оролцоог нэмэгдүүлэх зэрэг олон эерэг алхам хийгдэж байна. Авлигын эсрэг хууль хэрэгжиж, хууль зөрчсөн албан тушаалтанд хариуцлага тооцох механизм ил тод болсон. Иргэд эрхээ мэддэг, шаардаж чаддаг болж буй нь хууль хэрэглээ нь бүх нийтэд адил тэгш үйлчлэх нөхцөлийг бүрдүүлэхэд чухал нөлөө үзүүлж байна.

Хүний эрхийн үндэсний комиссын Увс аймаг дахь референтэд 2023, 2024 онд торгуулийн арга хэмжээний хүрээнд иргэний эрх зөрчигдсөн талаар ямар нэгэн гомдол гаргаагүй байна.

Торгууль ногдуулж байгаа хууль хэрэглээ нь бүх нийтэд адил тэгш үйлчлэх эрх зүйн орчин нь бүрдсэн байна. Орон нутгийн түвшинд хуулийн хэрэглээ нь бүх нийтэд адил тэгш үйлчилж чадаж байгаа эсэхийг аудитын явцад цуглуулсан нотлох баримтын хүрээнд дүгнэх боломжгүй байна.

1.3.6. Орлого бүрдүүлэлтийн эрхзүйн үндэслэлд шинэчлэл, сайжруулалт хийх хэрэгцээ шаардлага байна.

Увс аймгийн хэмжээнд дараах байгууллага, аж ахуйн нэгжүүд 2023 онд 67,898.2 мянга, 2024 онд 133,756.1 мянга, нийт 201,658.5 мянган төгрөгийн хүүгийн орлого төвлөрүүлсэн байна. Үүнд:

- ❖ Увс аймгийн Нийгмийн даатгалын газар 2023 онд 55,839.5 мянга, 2024 онд 53,657.9 мянга, нийт 109,497.4 мянган төгрөгийн,
- ❖ Увс аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 2024 онд 902.6 мянган төгрөгийн,
- ❖ Авто тээврийн төв 2023 онд 66.5 мянга, 2024 онд 365.6 мянга, нийт 432.1 мянган төгрөгийн,
- ❖ Улаангом тохижилт үйлчилгээ ОНТҮГ 2023 он 67.8 мянга, 2024 онд 182.9 мянга, нийт 250.7 мянган төгрөгийн,
- ❖ “Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК 2023 онд 10,327.1 мянга, 2024 онд 76,883.6 мянга, нийт 87,210.8 мянган төгрөгийн,
- ❖ “УВС-АЗЗА” ТӨХК 2024 онд 5.0 мянган төгрөгийн,



- ❖ “Увс цахилгаан түгээх” ХХК 2024 онд 94.9 мянган төгрөгийн,
- ❖ “Чандмань Увс” ХХК 2024 онд 239.8 мянган төгрөгийн,
- ❖ “Улаангомын дулааны 2-р станц” ТӨХК 2023 онд 1,597.3 мянга, 2024 онд 3,025.3 мянган төгрөгийн хүүгийн орлого төвлөрүүлсэн байна.

Хүүгийн орлого төвлөрүүлсэн байгууллага, аж ахуйн нэгжүүдийн хувьд авч үзэхэд хүүгийн хувь хэмжээ харилцан адилгүй, 2023 онд зарим байгууллага, аж ахуйн нэгж хүүгийн орлого төвлөрүүлээгүй байгаа нь салбар, нэгжийнх нь хуульд шинэчлэл, сайжруулалт хийх хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна.

Түүнчлэн хүүгийн орлого төвлөрүүлж байгаа байгууллага, аж ахуйн нэгжүүдийн мөрдөж байгаа хуулийн зохицуулалтаас Нийгмийн даатгалын Ерөнхий хуульд хүүгийн орлогыг зохицуулсан зүйл заалт тусгагдсан байна. Харин арилжааны банкаар төлбөр тооцоо гүйцэтгэж, хүүгийн орлого төвлөрүүлдэг бусад төсөвт байгууллага, Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдэд мөрдөгдөж байгаа хууль, эрх зүйн орчин нарийвчилсан зохицуулалт байхгүй, Банкны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт “Банк Монгол Улсын болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн /цаашид “иргэн” гэх/, хуулийн этгээдийн мөнгөн хөрөнгийг тэдгээрийн хүсэлтийн дагуу гэрээний үндсэн дээр хадгалж, түүнд хүү төлж болно”, Монгол банкны ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайдын 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн хамтарсан тушаалаар “Харилцах дансны үлдэгдэлд тооцох хүүгийн хэмжээг 3 хувь байна” гэж тогтоосны дагуу хүүгийн орлого төвлөрүүлж байна.

Цаашид арилжааны банкаар төлбөр тооцоо гүйцэтгэж байгаа байгууллага, аж ахуйн нэгжүүдийн хувьд арилжааны банканд байгаа дансанд хүү бодож тооцуулах талаар салбарын хуулийн хүрээнд эрх зүйн зохицуулалттай болох шаардлагатай байна.

Торгуулийн орлого бүрдүүлэлтийг зохицуулж байгаа Зөрчлийн тухай хуульд заасан хувь хэмжээгээр Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Захиргааны ерөнхий хуульд заасан эрх бүхий байгууллага, албан тушаалтнууд хэрэгжүүлж байна. Аудитын тайлангийн 1.3.3-д тусгасан зөрчилд холбогдуулан холбогдох хуульд шинэчлэл, сайжруулалт хийх шаардлагатай дараах саналыг аудитын нэгтгэл тайланд тусгуулахаар хүргүүлж байна. Үүнд:

- ✓ Зөрчлийн тухай хуулийн 7.11 дүгээр зүйлийн 7.11.3-т “Үнэт металл, эрдэнийн чулууны сорьц, чанарыг тогтоолгох, эсхүл бүртгүүлэх журам зөрчсөн бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж заасан нь Сорьцын хяналтын улсын байцаагчийн шийдвэрлэх хэргийн харьяалалд хамаарахаар байхад Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.42-т энэхүү зөрчлийг геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч шалган шийдвэрлэхээр заасныг Сорьцын хяналтын улсын байцаагч шалган шийдвэрлэх болгон өөрчлөн тусгах.
- ✓ Захиргааны ерөнхий хуулийн 85 дугаар зүйлийн 85.2 дахь хэсэгт “Захиргааны шийдвэрээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй этгээдэд захиргааны байгууллага хуульд заасан журмын дагуу албадлага хэрэглэнэ” гэж заасанд нийцүүлэн албадлагыг ямар хэлбэрээр явуулах талаар холбогдох хууль тогтоомжид нарийвчилсан зохицуулалтыг тусгах.

**1.3.7. Хүү, торгуулийн орлого нь иргэний өмчийн халдашгүй байдалтай зөрчилдсөн асуудал байхгүй байна.**

Өмчийн халдашгүй байдал нь хүний эрхийн үндсэн баталгаа бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан эрх юм. Монгол Улсын үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар “Хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө” гэж зааснаар иргэний өмчлөх эрхийн халдашгүй байдлыг баталгаажуулж өгсөн байна.

Хуулийн хүрээнд ногдуулсан торгуулийг заасан хугацаанд төлөөгүйгээс Шүүхийн шийдвэр гарч шийдвэрлэгдсэн тохиолдолд иргэний өмчид халдсан гэж үзэх үндэслэлгүй байна.

Зөрчлийн тухай хуулийн дагуу торгох шийтгэлийг хүлээж хугацаандаа биелүүлээгүйн улмаас аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас 2020 оноос хойш албадлагын арга хэмжээ авагдаж дууссан 1344 иргэн, хуулийн этгээдийн 914,103.3 мянган төгрөгийн төлбөр, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж байгаа 35 иргэн, хуулийн этгээдийн 365,327.4 мянган төгрөгийн төлбөр байна.

Энэ нь торгох шийтгэлийг хүлээж хугацаандаа биелүүлээгүй иргэн, хуулийн этгээдийн хувьд өмчийн халдашгүй байдлыг хуулийн хүрээнд хязгаарлах зохицуулалттай байна.

**БҮЛЭГ 2**

Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлтийг хууль, журамд нийцүүлэн төвлөрүүлсэн байна.

2.1. Ногдуулсан хүү, торгуулийн орлогыг төсөвт 98.3 хувьтай төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлт хангагдсан байна.

2.1.1. Хууль, журмын дагуу тогтоосон торгуулийн орлогоос 2023 онд 98 хувийг, 2024 онд 98.6 хувийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Увс аймгийн хэмжээнд 2023, 2024 онд дараах байгууллага, нэгжүүд улс, орон нутгийн төсөвт торгуулийн орлого төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 8. Тайлант онд илрүүлсэн зөрчил, түүнд ногдуулсан торгуулийн дүн

№	Байгууллагын нэр	2023 он		2024 он	
		Зөрчлийн тоо	Ногдуулсан дүн	Зөрчлийн тоо	Ногдуулсан дүн
1	Увс аймгийн Цагдаагийн газар	31,522	987,477.0	26,212	1,004,845.5
2	Татварын газар	38	226,732.5	36	410,192.5
3	Байгаль орчны газар	26	12,138.6	11	7,103.5
4	Улсын бүртгэлийн хэлтэс	415	9,300.0	550	11,250.0
5	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	2	6,000.0	1	4,000.0
6	Эрүүл мэндийн газар	8	5,300.0	5	2,300.0
7	Увс аймгийн Автотээврийн төв	81	4,440.0	47	4,690.0
8	Нийгмийн даатгалын газар	19	3,350.0	1	250.0
9	Хүнс, хөдөө аж ахуйн газар	5	3,000.0	8	3,500.0
10	Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газар	5	1,400.0	3	900.0
11	Онцгой байдлын газар	10	1,000.0	6	8,400.0
12	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар	2	600.0	22	8,300.0
13	Увс аймгийн Мал эмнэлгийн газар	1	500.0	12	4,350.0
14	Увс нуурын ай савын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа	1	500.0		-
15	Санхүү төрийн сангийн хэлтэс	1	400.0	10	4,000.0
16	Увс аймаг дахь Гаалийн газар	4	400.0	13	3,550.0
17	Аймгийн Засаг даргын Тамгын газар	1	300.0	9	5,850.0
18	Архивын газар	1	300.0		-
19	Увс аймаг дахь ШШГГ	1	250.0		-
20	Гадаадын иргэн харьяатын газар баруун бүс дэх газар Увс аймаг дахь хэлтэс	3	120.0	12	1,860.0
21	Боловсролын газар		-	2	4,000.0
22	Улаангом сумын засаг даргын тамгын газар		-	1	200.0
Нийт		32,146	1,263,508.1	26,961	1,489,541.5

Эх сурвалж: Аудитын хүрээнд авсан нэгтгэл судалгаа



2023 онд 32,146 зөрчил илрүүлж, 1,263,508.1 мянган төгрөгийн торгууль ногдуулсан бол 2024 онд 26,961 зөрчил илрүүлж, 1,498,541.5 мянган төгрөгийн торгууль ногдуулжээ. Нийт торгуулийн 72.4 хувийг Цагдаагийн газар, 23.1 хувийг Татварын газар, 4.5 хувийг бусад байгууллага ногдуулсан байна.

Торгуулийн орлого төвлөрүүлсэн байдлыг байгууллага бүрээр нь хувьчилж харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 9. Торгуулийн төвлөрсөн орлогын эзлэх хувь

№	Байгууллагын нэр	2023	2024
1	Увс аймгийн Цагдаагийн газар	80.2	114.8
2	Татварын газар	97.4	73.9
3	Байгаль орчны газар	81.9	100.0
4	Улсын бүртгэлийн хэлтэс	100.0	100.0
5	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	100.0	100.0
6	Эрүүл мэндийн газар	100.0	100.0
7	Увс аймгийн Автотээврийн төв	100.0	100.0
8	Нийгмийн даатгалын газар	100.0	100.0
9	Хүнс, хөдөө аж ахуйн газар	100.0	100.0
10	Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газар	100.0	100.0
11	Онцгой байдлын газар	100.0	100.0
12	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар	100.0	86.7
13	Увс аймгийн Мал эмнэлгийн газар	100.0	100.0
14	Увс нуурын ай савын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа	100.0	-
15	Санхүү төрийн сангийн хэлтэс	100.0	100.0
16	Увс аймаг дахь Гаалийн газар	100.0	100.0
17	Аймгийн Засаг даргын Тамгын газар	100.0	100.0
18	Архивын газар	100.0	-
19	Увс аймаг дахь ШШГГ	100.0	-
20	Гадаадын иргэн харьяатын газар баруун бүс дэх газар увс аймаг дахь хэлтэс	100.0	100.0
21	Боловсролын газар	-	-
22	Улаангом сумын засаг даргын тамгын газар	-	100.0
	Дундаж хувь	98.0	98.6

Эх сурвалж: Аудитын хүрээнд авсан нэгтгэл судалгаа

Торгууль төлөлтийн байдлыг байгууллагаар авч үзэхэд дийлэнх байгууллагуудын торгуулийн төлөлт бүрэн биелсэн байгаа бөгөөд төсөвт торгуулийн орлого их төвлөрүүлдэг байгууллагын хувьд биелэлт 70-аас дээш хувьтай байна.

Торгуулийн төлөлт дунджаар 2023 онд 98 хувь, 2024 онд 98.6 хувийн биелэлттэй байна.

Зөрчлийн тухай хуулийн дагуу торгох шийтгэлийг хүлээж хугацаандаа биелүүлээгүй бол тухайн торгууль ногдуулсан байгууллага, эрх бүхий албан тушаалтан нь хуулийн байгууллагад хандаж шийдвэрлүүлж байна.



Нийт торгуулийн 72.4 хувийг дангаараа бүрдүүлж байгаа Цагдаагийн байгууллагын торгууль ногдуулах эрх бүхий албан хаагчдын илрүүлсэн зөрчлийг тоймлон дурдвал. Үүнд:

- Ажлын тоормосны систем, жолооны механизм ажиллахгүй, чиргүүлийн холбоос /чиргүүлтэй үед/ эвдэрсэн, эсхүл харанхуй, үзэгдэх орчин хязгаарлагдмал үед гадна талын гэрэлтүүлэх хэрэгсэл нь бүрэн бус тээврийн хэрэгслээс бусад ашиглахыг хориглосон бүрэн бус тээврийн хэрэгсэл жолоодсон;
- Замын хөдөлгөөний дүрэмд зааснаар тээврийн хэрэгслийн жолооч, эсхүл зорчигч хамгаалах бүс хэрэглээгүй;
- Замын хөдөлгөөний дүрмийг сахин биелүүлээгүй;
- Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй /жолоодлогын дадлага хийхээс бусад тохиолдолд/, эсхүл тээврийн хэрэгсэл жолоодох эрх нь дуусгавар болсон хүн тээврийн хэрэгсэл жолоодсон;
- Техникийн хяналтад ороогүй автотээврийн хэрэгслийг замын хөдөлгөөнд оролцуулсан;
- Улсын бүртгэлийн дугаар нь танигдахгүй бохирдсон, эсхүл дугаарыг буруу байрлуулсан тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцсон;
- Жолооч тээврийн хэрэгслийн холын гэрлийг ойрын гэрэлд шилжүүлээгүй, эсхүл тээврийн хэрэгслийн гадна талын гэрэлтүүлэх хэрэгсэл хэрэглэх журам зөрчсөн;
- Тээврийн хэрэгсэл жолоодох үед хөдөлгөөнт утас хэрэглэсэн;
- Жолооч гэрлэн, эсхүл зохицуулагчийн дохиог зөрчин замын хөдөлгөөнд оролцсон;
- Мотоцикл, мопедын жолооч, эсхүл зорчигч хамгаалалтын малгай өмсөөгүй;
- Жолооч согтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон;
- Жолооч тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй, эсхүл жолоодох эрх нь дуусгавар болсон хүн согтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон;
- Замын хөдөлгөөний дүрэмд зааснаар жолооч тээврийн хэрэгслийг түр, удаан зогсоох журам зөрчсөн.

Зураг 3. Ногдуулсан торгуулийн орлого, төвлөрүүлсэн орлого

/мянган төгрөгөөр/



Эх сурвалж: Аудитын хүрээнд авсан нэгтгэл судалгаа

Хамгийн өндөр торгуулийн орлого төсөвт төвлөрүүлж байгаа Цагдаагийн байгууллагын хувьд он дамжсан төлөгдөөгүй торгуулийн орлого тайлант онуудад төвлөрсөнтэй холбоотойгоор 2024 онд ногдуулсан орлогоос төвлөрүүлсэн орлого өндөр харагдаж байна.

Цагдаагийн байгууллагын албан хаагчдын бэлэн бусаар буюу x-cover төхөөрөмжөөр торгосон торгуулийн төлөлтийг хянах боломжгүй бөгөөд нийтлэг тохиолдолд жолоодох эрхийн үнэмлэх авах, сунгах, ангилал нэмэх, өөрчлөх, нөхөн



авах, тээврийн хэрэгслийн эзэмшлийн шилжилт хөдөлгөөн хийх, оношилгоонд орох үед нь торгуулийн биелэлтийг хангуулж байна. Тиймээс зөвхөн Цагдаагийн байгууллагын хувьд төвлөрүүлсэн орлого ногдуулснаас өндөр дүнтэй байна.

2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн эрх бүхий албан тушаалтан, шүүхээс оногдуулсан торгох шийтгэлийг **хуулиар тогтоосон хугацаанд биелүүлэх бол шийтгэлийн хэмжээг 50 хувиар хөнгөрүүлэх**, хуульд заасан **хугацаанд биелүүлээгүй бол шийтгэлийн хэмжээг 50 хүртэл хувиар нэмэгдүүлнэ** гэж Зөрчлийн тухай хуулиар зохицуулжээ. Эдгээр хууль, журмын зохицуулалттай холбоотойгоор ногдуулсан орлого төвлөрүүлсэн орлого тэнцүү байх боломжгүй тул торгуулийн төвлөрүүлсэн орлогыг ногдуулсантай харьцуулан дүгнэх боломжгүй байна.

2.1.2. Торгуулийг эрх бүхий байгууллага, албан тушаалтан тавьсан байна.


Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6-д “Дараах эрх бүхий албан тушаалтан харьяаллын дагуу зөрчлийг шалган шийдвэрлэнэ” гэж заасны дагуу Увс аймгийн хэмжээнд нийт 24 байгууллагын 315 торгох эрх бүхий албан тушаалтан байна.

Зураг 4. Эрх бүхий албан тушаалтан боловсрол түвшнээр



Эрх бүхий албан тушаалтныг боловсролын түвшнээр авч үзвэл 85.1 хувь буюу 268 албан тушаалтан дээд боловсролтой, 8.6 хувь буюу 27 албан тушаалтан бүрэн дунд, 6.3 хувь буюу 20 албан тушаалтан тусгай мэргэжлийн дунд боловсролтой байна.

Зураг 5. Эрх бүхий албан тушаалтан ажилласан жилээр



Эрх бүхий албан тушаалтныг ажилласан жилээр авч үзэхэд 34.2 хувь буюу 108 албан тушаалтан 1-5 жил, 22.9 хувь буюу 72 албан тушаалтан 6-10 жил, 42.9 хувь буюу 135 албан тушаалтан 11 ба түүнээс дээш жил ажиллажээ.



Хүснэгт 10. Торгох эрх бүхий албан тушаалтныг байгууллагаар задлан харуулбал:

Д/д	Байгууллагын нэр	Эрх бүхий албан тушаалтны тоо	Эрх бүхий албан тушаалтан
1	Увс аймаг дахь Гаалийн газар	24	Гаалийн улсын байцаагч
2	Аймгийн Засаг даргын Тамгын газар	6	- Геологи, уул уурхай, газрын тос хийн хяналтын улсын байцаагч - Автотээвэр (усан зам)-ийн хяналтын улсын байцаагч - Авто замын хяналтын улсын байцаагч - Харилцаа холбооны хяналтын улсын байцаагч - Эрчим хүчний хяналтын улсын байцаагч - Байгаль орчны хяналтын улсын байцаагч
3	Улсын бүртгэлийн хэлтэс	1	Улсын бүртгэлийн хяналтын улсын байцаагч
4	Санхүү төрийн сангийн хэлтэс	1	
5	Улаангом сумын засаг даргын тамгын газар	1	Байгаль орчны хяналтын улсын байцаагч
6	Увс нуурын ай савын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа	6	Улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч
7	Нийгмийн даатгалын газар	24	Нийгмийн даатгалын улсын байцаагч
8	Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газар	3	Хүүхдийн эрхийн улсын байцаагч
9	Татварын газар	38	Татварын улсын байцаагч
10	Увс аймгийн Цагдаагийн газар	142	
11	Боловсролын газар	1	Боловсролын хяналтын улсын байцаагч
12	Гадаадын иргэн харьяатын газар баруун бүс дэх газар Увс аймаг дахь хэлтэс	3	Гадаадын иргэний хяналтын улсын байцаагч
13	Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар	4	Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч
14	Онцгой байдлын газар	5	- Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч - Гал түймрийн улсын хяналтын байцаагч
15	Байгаль орчны газар	19	Байгаль орчны хяналт
16	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар	3	- Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч - Газар, геодези, зураг зүйн хяналтын улсын байцаагч
17	Эрүүл мэндийн газар	5	Эмчилгээний чанарын хяналтын улсын байцаагч



			Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч
18	Увс аймаг дахь ШШГГ	2	•
19	Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар	2	• Соёлын хяналтын улсын байцаагч
20	Хүнс, хөдөө аж ахуйн газар	4	- Ургамал хамгааллын хяналтын улсын байцаагч - Хүнсний чанар стандартын хяналтын улсын байцаагч - Мал үржлийн технологийн хяналтын улсын байцаагч
21	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	3	- Хөдөлмөрийн хяналтын улсын ахлах байцаагч - Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч
22	Увс аймгийн Мал эмнэлгийн газар	15	• Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч
23	Увс аймгийн Авто тээврийн төв	2	• Авто тээврийн хяналтын улсын байцаагч
24	Архивын газар	1	• Архив, албан хэрэг хөтлөлтийн хяналтын улсын байцаагч
Нийт		315	

Эх сурвалж: Аудитын хүрээнд авсан нэгтгэл судалгаа

Увс аймгийн хэмжээнд 2023-2024 онд торгох эрх бүхий албан тушаалтан 59,107 зөрчил илрүүлж, 2,762,049.6 мянган төгрөгийн торгуулийг ногдуулжээ.

2.1.3. Орлого бүрдүүлэлтийг санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд үнэн зөв тусгасан байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.5 дахь заалтад “бүх орлого” гэж тусгасан байна.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд торгуулийн орлогыг 2023 онд 850,000.0 мянган төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 1,238,678.9 мянган төгрөг, 2024 онд 1,050,000.0 мянган төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 1,311,372.1 мянган төгрөг оруулсан, сумдын хувьд 2024 онд 609,500.0 мянган төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 618,349.3 мянган төгрөг төвлөрүүлснийг Төсвийн ерөнхийлөн захирагч, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд нэгтгэн тусгасан байна.

Хүснэгт 11. Аймаг, сумдын торгуулийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл 2023, 2024 оны хувьд дараах байдалтай байна. Үүнд:

Д/д	Сумын нэр	2023 он		2024 он	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Баруунтуруун	-		20,000.0	4,361.5
2	Бөхмөрөн	-		20,000.0	2,712.5
3	Давст	-		10,000.0	
4	Завхан	-		20,000.0	2,190.6
5	Зүүнговь	-		20,000.0	5,399.0

/мянган төгрөг/



6	Зүүнхангай	-		20,000.0	5,083.5
7	Малчин	-		45,000.0	37,899.0
8	Наранбулаг	-		20,000.0	9,384.5
9	Өлгий	-		20,000.0	2,667.5
10	Өмнөговь	-		20,000.0	10,720.5
11	Өндөрхангай	-		20,000.0	19,153.0
12	Сагил	-		15,000.0	4,585.0
13	Тариалан	-		105,000.0	118,422.5
14	Түргэн	-		45,000.0	50,996.7
15	Тэс	-		20,000.0	2,175.0
16	Ховд	-		24,500.0	49,144.0
17	Хяргас	-		20,000.0	5,082.3
18	Цагаанхайрхан	-	101.8	15,000.0	2,270.0
19	Улаангом	-		130,000.0	286,102.2
20	Аймгийн ИТХ	850,000.0	1,238,577.1	1,050,000.0	1,311,372.1
Нийт дүн		850,000.0	1,238,678.9	1,659,500.0	1,929,721.4

Эх сурвалж: Аймаг, сумдын төсөв захирагчийн санхүүгийн тайлан

Сумдын хувьд 2023 онд торгуулийн орлогыг төлөвлөөгүй, шууд аймагт төвлөрүүлж байсан байна.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн тайланд хүүгийн орлого байхгүй, 2024 оны санхүүгийн тайланд 239.8 мянган төгрөгийн хүүгийн орлого тайлагнасан нь Чандмань-Увс ХХК-ийн хүүгийн орлого байна.

2.1.4. Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлт нь төсвийн орлогын бусад эх үүсвэрт нөлөөлж байна.

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт “Төсвийн орлого нь татварын орлого, татварын бус орлогоос бүрдэнэ” гэж заасны дагуу Увс аймгийн 2023, 2024 оны төсвийн орлогыг дараах нэр төрлийн орлогоос бүрдүүлэхээр төлөвлөн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан байна.

Хүснэгт 12. Төсвийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэл орлогын нэр төрлөөр

д/д	Орлогын нэр төрөл	2023 он		2024 он	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1.	Аймгийн төсвийн орлого бүгд	4,302,405.6	3,191,392.5	4,598,500.0	4,759,112.0
1.1.	Татварын орлого	1,500,500.0	1,247,641.8	2,065,000.0	2,612,553.0
1.1.1	Авто тээврийн болон өөрөө явагч	700,000.0	715,294.4	750,000.0	970,083.1
1.1.2	Төсвийн тухай хуулийн 23.4.9-д зааснаас бусад улсын тэмдэгтийн хураамж	150,500.0	206,207.5	115,000.0	358,056.5
1.1.3	Аж ахуйн нэгжийн орлогын албан	650,000.0	326,139.9	1,200,000.0	1,284,413.4
1.2	Татварын бус орлого	2,801,905.6	1,943,750.7	2,533,500.0	2,146,559.0
1.2.1	Хүү, торгуулийн орлого	850,000.0	1,238,678.9	1,050,000.0	1,311,372.1
1.2.2	Газрын төлбөр	70,000.0	34,339.2	350,000.0	34,718.0
1.2.3	Газрын дуудлага худалдааны орлого	445,000.0	180,220.4		

/мянган төгрөгөөр/



1.2.4	Усны нөөц ашигласны төлбөр	35,000.0	33,403.2	30,000.0	46,929.8
1.2.5	Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны	45,000.0	200,904.0	280,000.0	256,053.7
1.2.6	Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого /Дамжуулан	681,905.6		87,500.0	
1.2.7	Нэр заагдаагүй бусад орлого	675,000.0	256,205.0	535,000.0	497,485.4

Эх сурвалж: Аймгийн 2023, 2024 оны ИТХ-ын тогтоол

Аймгийн хүү, торгуулийн орлогыг 2023 онд 850,000.0 мянга, 2024 онд 1,050,000.0 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 2023 онд 1,238,678.9 мянга, 2024 онд 1,311,372.1 мянган төгрөг төвлөрүүлсэн байна. Гүйцэтгэлээр 2023 оны нийт төсвийн 27 хувь, 2024 оны нийт төсвийн 39 хувийг, 2023 оны татварын бус орлогын 63.7 хувь, 2024 оны татварын бус орлогын 61.1 хувийг бүрдүүлсэн байна.

Зураг 6. Хүү, торгуулийн орлогын эзлэх хувь



Эх сурвалж: 2023, 2024 оны ИТХ-ын тогтоол

Харин сумдын хувьд 2024 оны төсвийн тодотгол хийх үед хүү, торгуулийн орлогыг нэмж төлөвлөн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан байна.

Хүснэгт 13. 2024 оны сумдын ИТХ-аар баталсан төсвийн орлогын гүйцэтгэлд хүү, торгуулийн орлогын эзлэх хувь

/мянган төгрөгөөр/

Д/д	Сумын нэр	Сумын нийт орлого		Үүнээс хүү, торгуулийн орлого		Хүү, торгуулийн орлогын эзлэх хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
1	Баруунтуруун	1,008,273.4	1,246,135.8	20,000.0	4,361.5	0.35%
2	Бөхмөрөн	821,936.9	978,725.0	20,000.0	2,712.5	0.28%
3	Давст	265,618.6	363,894.4	10,000.0	-	
4	Завхан	379,786.8	391,357.2	20,000.0	2,190.6	0.56%
5	Зүүнговь	519,239.1	636,519.4	20,000.0	5,399.0	0.85%
6	Зүүнхангай	487,434.5	518,362.9	20,000.0	5,083.5	0.98%
7	Малчин	544,166.5	557,640.0	45,000.0	37,899.0	6.80%
8	Наранбулаг	544,269.5	656,733.4	20,000.0	9,384.5	1.43%
9	Өлгий	349,993.8	451,842.6	20,000.0	2,667.5	0.59%
10	Өмнөговь	1,018,285.0	932,709.7	20,000.0	10,720.5	1.15%



11	Өндөрхангай	631,728.8	747,369.9	20,000.0	19,153.0	2.56%
12	Сагил	525,061.9	589,851.0	15,000.0	4,585.0	0.78%
13	Тариалан	667,945.3	868,582.5	105,000.0	118,422.5	13.63%
14	Түргэн	398,630.5	469,118.0	45,000.0	50,996.7	10.87%
15	Тэс	679,070.3	835,850.8	20,000.0	2,175.0	0.26%
16	Ховд	579,975.2	706,900.1	24,500.0	49,144.0	6.95%
17	Хяргас	585,217.6	592,528.5	20,000.0	5,082.3	0.86%
18	Цагаанхайрхан	436,950.5	511,692.7	15,000.0	2,270.0	0.44%
19	Улаангом	14,421,402.7	17,908,607.5	130,000.0	286,102.2	1.60%
Нийт дүн		24,864,986.9	29,964,421.6	609,500.0	618,349.3	

Эх сурвалж: 2024 сумдын ИТХ-ын тогтоол

Дээрх хүснэгтээс харахад сумдын төсвийн гүйцэтгэлд торгуулийн орлого 0.3-13.6 хувийг эзэлж байна.

2.2. Торгуулиас бүрдсэн орлогыг хууль, журмын дагуу хуваарилсан ч гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хуваарилсан зардал хуульд заасан хувь хэмжээнд нийцэхгүй байна.

2.2.1. Төсвийг хуваарилах эрх бүхий байгууллага бүрэн эрхээ хэрэгжүүлсэн байна.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.2 дахь заалтад “Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн шатны жилийн төсвийн төслийг хэлэлцэн жил бүрийн 12 дугаар сарын 05-ны дотор батлах”, 8.5.3 дахь заалтад “Сум, дүүргийн Засаг дарга тухайн шатны жилийн төсвийн төслийг жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх”, 8.5.4 дэх заалтад “Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн шатны жилийн төсвийн төслийг хэлэлцэн жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор батлах”, 8.5.5 дахь заалтад “Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны жилийн батлагдсан төсвийг 12 дугаар сарын 31-ний дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх” гэж заасан байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 11/03 дугаар тогтоолоор 2023 оны төсөв батлахдаа хүү, торгуулийн орлогыг 850,000.0 мянган төгрөг байхаар тусгасан байна. Сумдын хувьд 2023 оны төсөв батлахдаа хүү, торгуулийн орлогыг төлөвлөөгүй байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 16/04 дүгээр тогтоолоор 2024 оны төсөв батлахдаа хүү, торгуулийн орлогыг 1,050,000.0 мянган төгрөг байхаар, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар 2024 оны төсвөө батлахдаа хүү, торгуулийн орлогыг нийт 609,500.0 мянган төгрөг байхаар баталсан байна.



2.2.2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан хуваарилсан зардал хуульд заасан хувь хэмжээнд нийцэхгүй байна.

Зөрчлийн тухай хуулиар оногдуулсан торгуулийн орлого нь улсын болон орон нутгийн төсөвт төвлөрдөг бөгөөд тухайн байгууллагад шууд зарцуулдаггүй байна. Харин хууль, журмаар тусгайлан зохицуулсан тодорхой чиглэлд зарцуулах боломжтой байна. Тухайлбал:

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал

- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46.1-д зөрчилд оногдуулсан торгох шийтгэлийг биелүүлж, төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүнгийн 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг дүрс бичлэгийн техник, хэрэгсэл, зөрчил болон эрүүгийн хэрэг хянан шалгах байгууллагын мэдээллийн нэгдсэн системийг сайжруулах ажилд, 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бусад ажилд зориулан дараагийн жилийн төсөвт тусгаж, санхүүжүүлнэ” гэж заажээ.
- Хууль зүйн сайд, Сангийн сайдын 152 дугаар хамтарсан тушаалын хавсралтаар баталсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журам”-ын 3-д Аймаг, нийслэлийн санхүүгийн байгууллага дараа жилийн төсвийн төслийг боловсруулахдаа энэ журмын 2-д заасан улсын орлогод оруулсан орлого болон төсөвт тушаасан мөнгөний **тухайн жилийн урьдчилсан гүйцэтгэлд үндэслэн** түүний 40 хувьтай тэнцэх хэмжээний орлогыг тооцож төсвийн зарлагад тусгай зүйл болгон тусгаж төлөвлөнө” гэж заажээ.

“Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журам”-д Аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тухайн жилийн төсвийг батлахдаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулсан хөрөнгийг аймаг, нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах Зөвлөл / цаашид Зөвлөл гэнэ/ -ийн нэрээр тусад нь нэр зааж батлахаас гадна тухайн сум, дүүргийн гэмт хэрэг, хэв журмын зөрчлийн гаралтыг харгалзан гаргасан хуваарийг үндэслэн сум, дүүрэг тус бүрээр нэр зааж батална. Уг хөрөнгийг сум, дүүргийн батлагдсан төсөв дээр нэмж олгоно гэж заасны дагуу аймаг, сумдын ИТХ-аар 2025 оны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг дараах байдлаар баталжээ. Батлагдсан санхүүжилтийг 2024 оны төвлөрүүлсэн торгуулийн орлогын гүйцэтгэлтэй харьцуулан харуулав.



Хүснэгт 14. 2024 онд төвлөрсөн торгуулийн орлого болон 2025 оны батлагдсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардал

/мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	2024 онд төвлөрсөн торгуулийн орлого	2025 оны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын төлөвлөгөө	2024 оны гүйцэтгэлд эзлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын хувь
1	Баруунтуруун сум	4,361.5	3,814.9	87.5
2	Бөхмөрөн сум	2,712.5	5,321.5	196.2
3	Давст сум	-	4,167.7	-
4	Завхан сум	2,190.6	3,936.0	179.7
5	Зүүнговь сум	5,399.0	3,936.0	72.9
6	Зүүнхангай сум	5,083.5	4,274.7	84.1
7	Малчин сум	37,899.0	3,907.0	10.3
8	Наранбулаг сум	9,384.5	4,296.8	45.8
9	Өлгий сум	2,667.5	3,936.0	147.6
10	Өндөрхангай сум	19,153.0	4,142.4	21.6
11	Сагил сум	4,585.0	4,023.0	87.7
12	Түргэн сум	50,996.7	3,936.0	7.7
13	Тэс сум	2,175.0	4,433.8	203.9
14	Хяргас сум	5,082.3	3,936.0	77.4
15	Цагаанхайрхан сум	2,270.0	4,008.7	176.6
16	Тариалан сум	118,422.5	4,306.1	3.6
17	Ховд сум	49,144.0	3,891.3	7.9
18	Өмнөговь сум	10,720.5	3,979.6	37.1
19	Улаангом сум	286,102.2	70,000.0	24.5
20	Аймгийн ИТХ	1,311,372.1	139,372.3	10.6
	Нийт	1,929,721.4	283,619.8	14.7

Эх сурвалж: Аймаг сумдын ИТХ-ын тогтоол, 2024 оны санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 2025 онд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилт нь 2024 онд төвлөрүүлсэн торгуулийн орлогын 14.7 хувийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл хуульд заасан хувь хэмжээнээс бага дүнгээр төлөвлөн тусгасан байна.

Түүнчлэн аймаг 10.6 хувьтай, хамгийн бага буюу Тариалан сумд 3.6 хувьтай байхад хамгийн өндөр буюу Тэс сум 203.9 хувьтай байна. Энэ нь төлөвлөлтийг бодитой хийхгүй байгааг харуулж байна.

Торгуулийн орлогоос гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хуваарилах зардлыг хуульд заасан хувь хэмжээгээр төлөвлөж байхыг зөвлөлөө.



2.2.3. Торгуулийн орлогын тодорхой хувийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан хуваарилсан байна.

Орон нутгийн түвшинд хүүгийн орлого төвлөрүүлсэн Нийгмийн даатгалын газар, Увс аймаг дахь ШШГГ, Автотээврийн төв гэсэн төсөвт байгууллагын хувьд хүүгийн орлогыг зарцуулах эрх байдаггүй бөгөөд Улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Харин Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн хувьд тухай бүр үндсэн үйл ажиллагаа болон төлбөр тооцоондоо зарцуулдаг байна.

Торгуулийн орлогын хувьд аймгийн ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 14/01 дүгээр тогтоолоор 2023 оны хүү, торгуулийн орлогыг 850,000.0 мянган төгрөгөөр, 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 21/01 дүгээр тогтоолоор 2024 оны хүү, торгуулийн орлогыг 1,050,000.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Ингэхдээ Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэгт "... зөрчилд оногдуулсан торгох шийтгэлийг биелүүлж, төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүнгийн 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг дүрс бичлэгийн техник, хэрэгсэл, зөрчил болон эрүүгийн хэрэг хянан шалгах байгууллагын мэдээллийн нэгдсэн системийг сайжруулах ажилд, 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бусад ажилд зориулан дараагийн жилийн төсөвт тусгаж, санхүүжүүлнэ", мөн Хууль зүйн сайд, Сангийн сайдын хамтарсан 88/152 дугаар тушаалаар баталсан "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журам"-ын 3-д "Аймаг, нийслэлийн санхүүгийн байгууллага дараа жилийн төсвийн төслийг боловсруулахдаа энэ журмын 2- д заасан улсын орлогод оруулсан орлого болон төсөвт тушаасан мөнгөний тухайн жилийн урьдчилсан гүйцэтгэлд үндэслэн түүний 40 хувьтай тэнцэх хэмжээний орлогыг тооцож төсвийн зарлагад тусгай зүйл болгон тусгаж төлөвлөнө" гэж заасны дагуу аймгийн ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 14/01 дүгээр тогтоолоор 2023 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 80,972.4 мянган төгрөг, 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 21/01 дүгээр тогтоолоор 2024 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 74,500.0 мянган төгрөгөөр тус тус баталж хуваарилсан байна.

Хүснэгт 15. Аймаг, сумдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга, хэмжээний зардлын хуваарилалт

/мянган төгрөг/

№	Сумын нэр	Аймаг, сумдын ИТХ-ын тогтоол	2023 он	Аймаг, сумдын ИТХ-ын тогтоол	2024 он
			Хуваарилагдсан зардал		Хуваарилагдсан зардал
1	Баруунтуруун	2023.07.25 №8/01	3,814.9	2024.09.27 №13	3,814.9
2	Бөхмөрөн	2023.07.27 №11/07	5,321.4	2024.09.24 - 16/03	5,321.4
3	Давст	2023.07.24 №14/01	4,167.7	2024.09.25 18/01	6,167.7
4	Завхан	2023.07.25 №11/01	4,736.0	2024.11.05 №2/01	3,936.0
5	Зүүнговь	2023.07.27 №12/01	3,936.0	2024.09.25 №18/02	3,936.0
6	Зүүнхангай	2023.07.25	4,274.7	2024.10.08	4,274.7



		№13/01		№18/01	
7	Малчин	2023.07.25 №А/05	3,907.0	2024.09.25 №А/11	3,907.0
8	Наранбулаг	2023.07.22 №15/01	4,296.8	2024.10.15 №22/01	4,296.8
9	Өлгий	2023.07.28 №11/01	3,936.0	2024.09.23 №16/01	3,936.0
10	Өмнөговь	2023.07.28 №12/01	4,979.6	2024.09.27 №18/01	3,979.6
11	Өндөрхангай	2023.07.27 №15/01	4,141.7	2024.09.27 №22/01	4,141.7
12	Сагил	2023.07.28 №11/03	4,023.0	2024.11.13 №2/01	4,023.0
13	Тариалан	2023.07.25 №13/01	5,306.1	2024.09.30 №17/01	4,306.1
14	Түргэн	2023.07.28 №12/02	5,436.0	2024.09.20 №18/04	3,936.0
15	Тэс	2023.08.04 №11/01	4,433.8	2024.09.20 №16/01	4,433.8
16	Ховд	2023.07.25 №13/01	3,891.3	2024.09.24 №18/03	3,891.3
17	Хяргас	2023.07.27 №11/01	3,936.0	2024.09.23 №18/01	3,936.0
18	Цагаанхайрхан	2023.07.28 №13/01	4,008.7	2024.09.20 №18/01	4,008.7
19	Улаангом	2023.07.27 №15/04	54,862.0	2024.09.24 №22/04	105,000.0
20	Аймгийн ИТХ	2023.07.21 №14/01	80,972.4	2024.09.18 №21/01	74,500.0
Нийт дүн			214,381.1		255,746.7

Эх сурвалж: Аудитын хүрээнд авсан нэгтгэл судалгаа

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дээрх зохицуулалтаас өөр хүү, торгуулийн орлогыг хуваарилах нарийвчилсан зохицуулалт байхгүй, улс, орон нутгийн төсвийн орлогод төвлөрч, орон нутгийн хувьд аймаг, сумдын ИТХ-аар тухайн жилийн төсөв батлахдаа хуваарилж байна.

2.2.4. Орлогын төлөвлөгөө биелүүлсэн байдал, төвлөрүүлсэн орлогын хэмжээгээр албан хаагчдын ажил дүгнэх үзүүлэлтийг харгалзан үзээгүй байна.

Торгуулийн орлогыг Сангийн яамнаас ирүүлсэн суурь тоонд үндэслэн аймгийн хэмжээнд багц дүнгээр төлөвлөн, сумдад хуваарилж батлуулж байна.

Аудитад хамрагдсан 22 төсвийн шууд захирагч, 9 төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж нь хүү, торгуулийн орлогыг 2023, 2024 онд төлөвлөөгүй байна.

Аудитын явцад тухайн байгууллага, аж ахуйн нэгжүүдэд очиж уулзалт ярилцлага хийхэд хүү, торгуулийн орлого төвлөрүүлсэн хэмжээгээр албан хаагчдын ажил дүгнэх үзүүлэлтийг харгалзан үзээгүй байна.

**БҮЛЭГ 3**

Торгуулийн орлогоос хуулийн хүрээнд хуваарилсан зардлын гүйцэтгэл зохих үр дүнтэй байна.

3.1. Хүүгийн орлого, торгуулийн орлогоос гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хуваарилсан зардлыг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулсан байна.

3.1.1. Хүүгийн орлого, торгуулийн орлогоос гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хуваарилсан зардлыг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулсан байна.

Аймгийн хэмжээнд дараах Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүд 2023 онд 6,263.5 мянга, 2024 онд 22,936.6 мянга, нийт 29,200.1 мянган төгрөгийн хүүгийн орлого зарцуулсан байна.

Хүснэгт 16. Хүүгийн орлогын зарцуулалт

<i>/мянган төгрөг/</i>				
Д/д	Хуулийн этгээдийн нэр	2023	2024	нийт
1	Улаангом тохижилт үйлчилгээ ОНТҮГ	67.8	182.9	250.7
2	ББЭХС ТӨХК	4,628.0	21,290.3	25,918.3
3	АЗЗА ТӨХК		4.9	4.9
4	Увс ЦТС ХХК		86.1	86.1
5	"Улаангомьн дулааны 2-р станц" ТӨХК	1,567.7	1,372.4	2,940.0
	Нийт	6,263.5	22,936.6	29,200.1

Эх сурвалж: Аудитын хүрээнд авсан нэгтгэл судалгаа

Дээрх Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүд хүүгийн орлогыг тухайн үеийн үйл ажиллагааны зардал болон төлбөр тооцоондоо зориулалтын дагуу зарцуулсан байна.

Зөрчлийн тухай хуулиар оногдуулсан торгуулийн орлого нь улсын болон орон нутгийн төсөвт төвлөрдөг бөгөөд тухайн байгууллага нь зарцуулах эрхгүй тул зориулалтын дагуу зарцуулсан эсэхийг дүгнэх боломжгүй байна.

Түүнчлэн Улс орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн торгуулийн орлого нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсэгт "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 16.5.2 дахь заалтад батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэгт "Төрийн сангийн нийтлэг чиг үүрэг", 37.1.8 дахь заалтад "Төсвийн сар, улирлын хуваарьт үндэслэн төсвийн байгууллагын бүртгэлийн дансанд санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олгох", 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсэгт "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ" гэсэн заалтын хүрээнд хуваарилагдан зарцуулагддаг байна.



Харин хууль, журмаар тусгайлан зохицуулсан тодорхой чиглэлд хуваарилагдан зарцуулагдаж байгаа зардлын хувьд зориулалтын дагуу зарцуулсан байна. Үүнд:

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журмын 7-д “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан тусгай дансанд төвлөрүүлсэн хөрөнгийг сум, дүүргийн Зөвлөлийн шийдвэрийг үндэслэн тухайн шатны Засаг даргын захирамжаар дараах зориулалтаар зарцуулна”, 7.1-д “Хууль сахиулах, нутгийн захиргааны болон төрийн бус байгууллагуудаас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар иргэд, байгууллагын дунд зохиох эрх зүйн сургалт, сурталчилгааны зардлыг санхүүжүүлэх”, 7.2-д “Хэв журмын урамшилтай эргүүл, жижүүр томилох, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулах”, 7.3-д “Сум, дүүргийн нийгмийн хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийг томилох, урамшуулах”, 7.4-д “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар тодорхой ажил зохиож үр дүнд хүрсэн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг урамшуулах”, 7.5-д “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үүргээ гүйцэтгэж байгаад эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгөөр хохирсон тохиолдолд зохих журмын дагуу тэтгэвэр, тэтгэмж, цалингийн зөрүү, хиймэл эрхтэн хийх зардал болон бусад нөхөн төлбөрийг төлөх” гэж заасны дагуу аймаг, сумууд олгосон санхүүжилтийг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журам”-ын хүрээнд үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Аймаг, сумдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын 2023, 2024 оны батлагдсан төсөв, гүйцэтгэл дараах байдалтай байна.

Хүснэгт 17. Аймаг, сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

№	Сумын нэр	2023 он			2024 он		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Баруунтуруун	3,814.9	3,814.8	0.1	3,814.9	3,814.5	0.4
2	Бөхмөрөн	5,321.4	4,621.4	700.0	5,321.4	3,704.0	1,617.4
3	Давст	4,167.7	3,566.9	600.8	6,167.7	4,954.4	1,213.3
4	Завхан	4,736.0	4,434.7	301.3	3,936.0	3,370.0	566.0
5	Зүүнговь	3,936.0	2,691.0	1,245.0	3,936.0	1,422.5	2,513.5
6	Зүүнхангай	4,274.7	3,461.6	813.1	4,274.7	2,921.5	1,353.2
7	Малчин	3,907.0	3,904.5	2.5	3,907.0	3,901.0	6.0
8	Наранбулаг	4,296.8	3,966.3	330.5	4,296.8	3,183.5	1,113.3
9	Өлгий	3,936.0	3,868.3	67.7	3,936.0	3,936.0	-
10	Өмнөговь	4,979.6	4,974.5	5.1	3,979.6	1,575.6	2,404.0
11	Өндөрхангай	4,141.7	4,141.7	0.0	4,141.7	4,141.7	-
12	Сагил	4,023.0	2,810.1	1,212.9	4,023.0	3,976.5	46.5
13	Тариалан	5,306.1	5,158.7	147.4	4,306.1	3,614.6	691.5
14	Түргэн	5,436.0	3,758.4	1,677.6	3,936.0	3,728.5	207.5



15	Тэс	4,433.8	4,354.4	79.4	4,433.8	4,406.2	27.6
16	Ховд	3,891.3	1,689.0	2,202.3	3,891.3	2,059.5	1,831.8
17	Хяргас	3,936.0	3,921.8	14.3	3,936.0	3,936.0	-
18	Цагаанхайрхан	4,008.7	3,194.0	814.7	4,008.7	2,298.4	1,710.3
19	Улаангом	54,862.0	54,861.2	0.8	105,000.0	104,999.9	0.1
20	Аймгийн ИТХ	80,972.4	80,967.2	5.2	74,500.0	68,785.8	5,714.2
Нийт дүн		214,381.1	204,160.5	10,220.6	255,746.7	234,730.1	21,016.6

Эх сурвалж: Аймаг, сумдын төсвийн захирагчдын санхүүгийн тайлан, төсвийн хэлбэлзэл

Аймаг, сумдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын гүйцэтгэлийн дийлэнх хувь нь хууль сурталчлах, таниулах сургалт зохион байгуулах, гарын авлага танилцуулга бэлтгэх, хяналтын тоног төхөөрөмж түүний засвар үйлчилгээ, шатахууны зардалд зарцуулагдаж байна.

Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 дахь хэсэгт “Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ” гэж заасны дагуу аймаг, сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын зарцуулагдаагүй үлдэгдэл 2023 онд 10,220.6 мянга, 2024 онд 21,016.6 мянга, нийт 31,237.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Төрийн аудитын байгууллагаас төсвийн шууд захирагчдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын батлагдсан төсвийн гүйцэтгэлд жил бүр санхүүгийн тайлангийн аудитаар горим сорил хэрэгжүүлэн ажилладаг бөгөөд 2023 онд зориулалт бус зарцуулалттай холбоотой 2,500.0 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт, 2024 онд анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй 1,000.0 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өгсөн байна. Үүнд:

- Баруунтуруун сумын ИТХ нь 2023 онд “Үйлдлээрээ үлгэрлэгч Увсчууд” аяны хоолны зардалд 1.2 сая төгрөгийг зарцуулсанд төлбөрийн акт тогтоосон.
- Өмнөговь сумын ИТХ нь сумын ИТХ-ын даргын 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/15 дугаар захирамжаар “Үйлдлээрээ үлгэрлэгч Увсчууд” аяны хоолны зардалд 1.3 сая төгрөгийг зарцуулсанд төлбөрийн акт тогтоосон.
- Зүүнговь сумын ИТХ нь 2024 онд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын А/07 дугаар захирамжаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас хууль сурталчлах нөлөөллийн ажилд зарцуулсан 1.0 сая төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй зөрчилд зөвлөмж өгсөн.

Гүйцэтгэлийн аудитаар аймаг, сумдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын зарцуулалттай холбоотой зөрчил гараагүй болно.

3.1.2. Хүү, торгуулийн орлогыг эдийн засгийн ангилал хооронд шилжүүлэн, зарцуулаагүй байна.

Хүүгийн орлого төвлөрүүлж байгаа төсвийн байгууллагын эдийн засгийн ангилал хооронд шилжүүлж зарцуулаагүй байна. Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн хувьд хүүгийн орлогыг тухайн үеийн үйл ажиллагааны зардал болон төлбөр тооцоондоо зарцуулж байна.

Зөрчлийн тухай хуулиар оногдуулсан торгуулийн орлого нь улсын болон орон



нутгийн төсөвт төвлөрдөг бөгөөд эдийн засгийн ангилал хооронд шилжүүлж зарцуулах боломжгүй байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэгт “Зөрчилд оногдуулсан торгох шийтгэлийг биелүүлж, төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүнгийн 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг дүрс бичлэгийн техник, хэрэгсэл, зөрчил болон эрүүгийн хэрэг хянан шалгах байгууллагын мэдээллийн нэгдсэн системийг сайжруулах ажилд, 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бусад ажилд зориулан дараагийн жилийн төсөвт тусгаж санхүүжүүлнэ” гэж заасны дагуу хүү, торгуулийн орлогоос гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд зарцуулдаг байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын 2023, 2024 оны төлөвлөгөө, гүйцэтгэлийг харуулбал:

Хүснэгт 18. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын төлөвлөгөө, зарцуулалт

№	Сумын нэр	2023		2024	
		Батлагдсан зардал	Зардлын гүйцэтгэл	Батлагдсан зардал	Зардлын гүйцэтгэл
1	Баруунтуруун	3,814,900.0	3,814,825.0	3,814,900.0	3,814,500.0
2	Бөхмөрөн	5,321,400.0	4,621,400.0	5,321,400.0	3,704,000.0
3	Давст	4,167,700.0	3,566,900.0	6,167,700.0	4,954,400.0
4	Завхан	4,736,000.0	4,434,700.0	3,936,000.0	3,370,000.0
5	Зүүнговь	3,936,000.0	2,691,000.0	3,936,000.0	1,422,500.0
6	Зүүнхангай	4,274,700.0	3,461,600.0	4,274,700.0	2,921,500.0
7	Малчин	3,907,000.0	3,904,500.0	3,907,000.0	3,901,000.0
8	Наранбулаг	4,296,800.0	3,966,300.0	4,296,800.0	3,183,500.0
9	Өлгий	3,936,000.0	3,868,300.0	3,936,000.0	3,936,000.0
10	Өмнөговь	4,979,600.0	4,974,460.0	3,979,600.0	1,575,600.0
11	Өндөрхангай	4,141,700.0	4,141,680.0	4,141,700.0	4,141,700.0
12	Сагил	4,023,000.0	2,810,126.0	4,023,000.0	3,976,500.0
13	Тариалан	5,306,100.0	5,158,700.0	4,306,100.0	3,614,600.0
14	Түргэн	5,436,000.0	3,758,400.0	3,936,000.0	3,728,500.0
15	Тэс	4,433,800.0	4,354,400.0	4,433,800.0	4,406,170.0
16	Ховд	3,891,300.0	1,689,000.0	3,891,300.0	2,059,500.0
17	Хяргас	3,936,000.0	3,921,750.0	3,936,000.0	3,936,000.0
18	Цагаанхайрхан	4,008,700.0	3,194,000.0	4,008,700.0	2,298,400.0
19	Улаангом	54,862,000.0	54,861,240.0	105,000,000.0	104,999,900.1
20	Аймгийн ИТХ	80,972,400.0	80,967,236.0	74,500,000.0	68,785,830.0
Нийт дүн		214,381,100.0	204,160,517.0	255,746,700.0	234,730,100.1

Эх сурвалж: аймаг, сумдын ИТХ-ын санхүүгийн тайлан, төсвийн хэлбэлзэл

Аймаг, сумдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлыг эдийн засгийн ангилал хооронд шилжүүлэн, зарцуулаагүй байна.

**3.1.3. Хүү, торгуулийн орлогоор санхүүжүүлсэн арга хэмжээ нь олон нийтэд хүртээмжтэй байна.**

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэгт “Төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх явцад олон нийтийн оролцоог хангана” гэж заажээ.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг аймаг, сумдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл (ГХУСАЗСЗ), Прокурорын газар, Цагдаагийн газар, Байгаль орчны газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Шүүхийн шинжилгээний газар, Хилийн цэргийн 0245 дугаар анги, Боловсролын газар, аймгийн ИТХ, ЗДТГ-ын Цэргийн штаб, Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар, аймаг, сумдын Засаг дарга, Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөл зэрэг байгууллага, албан тушаалтнууд хариуцан хэрэгжүүлж байна.

Ингэхдээ 2023, 2024 онд хүрээлэн буй орчны эсрэг үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчил, мал хулгайлах гэмт хэрэг, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, цахим орчинд үйлдэгдэж буй хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчил, хилийн зурвас, бүсэд хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, гэр бүлийн хүчирхийлэл, замын хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, залилах зэрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх, ангид байх чиглэлээр сургалт, аян, уралдаан, тэмцээн, соён гэгээрүүлэх арга хэмжээг голчлон зохион байгуулсан байна.

Зохион байгуулсан арга хэмжээний хамрах хүрээний хувьд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсох чиглэлд тэргүүн эгнээнд ажилладаг Цагдаагийн байгууллагын алба хаагчдыг идэвхжүүлэх, урамшуулах, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгжийн ажилтан, албан хаагчид, Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, Улаангом политехник коллежийн оюутнууд, хамтарсан багийн гишүүд, малчид, эцэг, эх, асран хамгаалагч, багш, сурган хүмүүжүүлэгч зэрэг нийгмийн бүхий л сегментэд чиглэн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ангид байх чиглэлээр үйл ажиллагаа зохион байгуулсан байна.

Мөн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд бэлтгэгдсэн видео шторк, контент, постер, танилцуулга, зурагт хуудас зэргийг сонин, телевиз, цахим хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэсэн байна.

3.1.4. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил нь нийгэм, эдийн засагт зохих эерэг нөлөө үзүүлж байна.

Хууль зүйн сайд, Сангийн сайдын 152 дугаар хамтарсан тушаалын хавсралтаар баталсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журам”-ын 7-д “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан тусгай дансанд төвлөрүүлсэн хөрөнгийг сум, дүүргийн Зөвлөлийн шийдвэрийг үндэслэн тухайн шатны Засаг даргын захирамжаар дараах зориулалтаар зарцуулна” гэж заасан байна. Үүнд:



- ✓ Хууль сахиулах, нутгийн захиргааны болон төрийн бус байгууллагуудаас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар иргэд, байгууллагын дунд зохиох эрх зүйн сургалт, сурталчилгааны зардлыг санхүүжүүлэх;
- ✓ Хэв журмын урамшилтай эргүүл, жижүүр томилох, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулах;
- ✓ Сум, дүүргийн нийгмийн хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийг томилох, урамшуулах;
- ✓ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар тодорхой ажил зохиож үр дүнд хүрсэн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг урамшуулах;
- ✓ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үүргээ гүйцэтгэж байгаад эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгөөр хохирсон тохиолдолд зохих журмын дагуу тэтгэвэр, тэтгэмж, цалингийн зөрүү, хиймэл эрхтэн хийх зардал болон бусад нөхөн төлбөрийг төлөх;

Дээрх заалтын хүрээнд аймгийн хувьд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2023 онд 25 арга хэмжээнд 80,967.2 мянга, 2024 онд 23 арга хэмжээнд 68,785.8 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Сумдын хувьд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2023 онд 345 арга хэмжээнд 193.3 мянга, 2024 онд 379 арга хэмжээнд 165,944.3 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Аймаг, сумдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөнд дараах чиглэлийн ажлуудыг баталж хэрэгжүүлсэн байна. Тухайлбал:

- ✓ Залилан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах,
- ✓ Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх,
- ✓ Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх,
- ✓ Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн тоо, төрлийн талаар нормативыг ханган ажиллаж, түүнд тавих хяналтыг эрчимжүүлэх,
- ✓ Малын хулгай, хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх,
- ✓ Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх,
- ✓ Байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх,
- ✓ Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэд хяналт тавих,
- ✓ Замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль, журам зөрчих зөрчлөөс урьдчилан сэргийлэх,
- ✓ Хэвлэл мэдээллийн хэрэгслээр гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлийн мэдээ, мэдээлэл нэвтрүүлэх,
- ✓ Хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах,
- ✓ Зөрчлийн хэргийг бууруулахад шаардагдах техник, тоног төхөөрөмжөөр хангах гэх мэт,

Гэмт хэрэг зөрчлийг бууруулах, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд дээрх чиглэлээр тодорхой ажлуудыг төлөвлөн хэрэгжүүлсний үр дүнд нийгэм, эдийн засагт зохих эерэг үр дүн гарсан байна. Тухайлбал:

- ❖ 2024 онд мал хулгайлах гэмт хэргийн гаралт өмнөх онтой харьцуулахад 10.8 хувиар буурсан,
- ❖ Цагдаагийн газарт иргэд, аж ахуйн нэгжээс ирдэг гомдол мэдээллийн дуудлага 12.3 хувиар буурсан,
- ❖ Цахим залиланд өртөхөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд аймаг, сумдын 58 фейсбүүк групп, 22 цахим хаягаар урьдчилан сэргийлэх мэдээ мэдээлэл түгээсэн, Улаангом сумын томоохон худалдааны төвүүдэд хөдөлмөр эрхэлж байгаа нийт 835 иргэнд, мөн Улаангом сумын 7-12 дугаар ангийн 787 сурагч, Улаангом политехник коллежийн 98 оюутанд мэдээллийн аюулгүй байдлаа цахим орчинд хамгаалах, цахим худалдан авалтын хохирогч болохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт мэдээлэл хийсэн,
- ❖ Хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 5-12 дугаар ангийн сурагчдын 589 эцэг, эх асран хамгаалагч, Улаангом сумын 6,9,12 дугаар багийн 245 иргэд, төрийн 4 байгууллагын 184 ажилтан албан хаагчдад танхим болон цахим хэлбэрээр сургалт мэдээлэл



хийж, цахим орчинд хүүхдээ зохисгүй контент үзэхээс урьдчилан сэргийлэх, ухаалаг утас нь дээр хүүхдийн байршил тогтоох аргачлал, зөвлөмжийг өгсөн байна,

- ❖ “Үйлдлээрээ үлгэрлэгч Увсчууд” аяны хүрээнд Хүрээлэн буй орчны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжоор 13,488 иргэнд сургалт зохион байгуулсан байна.

3.2. Хүү, торгуулийн орлогоос хуваарилсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын гүйцэтгэлийг ил тод мэдээлж байна.

3.2.1. Хүү, торгуулийн орлогоос хуваарилсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын гүйцэтгэлийг шилэн дансны цахим хуудсаар мэдээлсэн байна.

Shilendans.gov.mn мэдээллийн нэгдсэн системд хүү, торгуулийн орлогын зарцуулалтыг бүртгэх тусгай цэс байхгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна”, 3.1.1 дэх заалтад “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд”, 3.1.2 дахь заалтад “Төрийн өмчит үйлдвэрийн газар” гэж заасны дагуу хүүгийн орлого төвлөрүүлдэг байгууллага, аж ахуйн нэгжүүд хүүгийн орлогоо, торгуулийн орлого хуваарилагдан зарцуулагдаж байгаа төсөвт байгууллагууд хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” гэж заасны дагуу тогтмол мэдээлсэн байна. Тухайлбал: Аймаг, сумдын ИТХ нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын зарцуулалтын холбогдох мэдээллийг мэдээлсэн байна.

Мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Байгууллага нь шилэн дансны мэдээллийг өөрийн цахим хуудсаар хүргэх бөгөөд цахим хуудас нь дараах шаардлагыг хангасан байна”, 5.1.1 дэх заалтад “Шилэн дансны бие даасан цэстэй байх”, 5.7 дахь хэсэгт “Орон нутгийн төсөв, түүний төсвийн захирагчийн шилэн дансны мэдээллийг энэ хуулийн 5.1-д заасан цахим хуудастай эсэхээс үл хамааран тухайн байгууллагын мэдээллийн самбарт байрлуулна” гэж заасны дагуу Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын зарцуулалтыг мэдээллийн самбарт байршуулсан байна.

3.2.2. Аймаг, сумдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс үйл ажиллагааны тайлангаа олон нийтэд мэдээлсэн байна.

Төсвийн тухай хууль 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэгт “Энэ хуулийн 5.1.4-т заасан төсвийн ил тод байдлыг хангасан байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 6.5.1 дэх заалтад “Төсөв хэлэлцэх, батлах үйл ажиллагааг нийтэд нээлттэй байлгаж, төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагналын талаар тогтоосон хугацаанд нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар мэдээлэх”, 6.5.2 дахь заалтад “Төсвийг төлөвлөх, бүрдүүлэх, хуваарилах, тайлагнах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах”, 6.5.3 дахь заалтад “Төсвийн гүйцэтгэл, зарцуулалт нь батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байгаа эсэхэд олон нийт хяналт тавих боломжоор хангах”, 68 дугаар зүйлийн 68.3 дахь хэсэгт “иргэдийн Төлөөлөгчдийн



Хурал, Зөвлөлөөс баталсан тухайн жилийн төсвийг ил тод, олон нийтэд хүртээмжтэй байдлаар мэдээлнэ” гэж заажээ.

Шат шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан хүү, торгуулийн орлогын зохих хувийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын санхүүжилтэд хуваарилан аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал захиран зарцуулсан бөгөөд тухайн зарцуулалттай холбоотой тушаал шийдвэрийг шилэн дансны тухай хуулийн дагуу цахим системд нийтлэн олон нийтэд мэдээлсэн байна.

Мөн аймаг, сумдын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл нь тухайн жилийн ажлын төлөвлөгөөний биелэлтийг аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид болон эрх бүхий албан тушаалтанд тайлагнадаг бөгөөд зохион байгуулж буй арга хэмжээг олон нийтийн цахим сүлжээнд мэдээлж байгаа ч гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зардлын зарцуулалтын тайланг олон нийтэд нээлттэй мэдээлсэн баримт байхгүй байна.

3.2.3. Иргэд, төрийн бус байгууллага, хяналтын зөвлөл зэрэг оролцогч талууд хүү, торгуулийн орлогын зарцуулалтын ил тод байдалд үнэлгээ өгөөгүй, санал хүргүүлээгүй байна.


Орон нутгийн түвшинд хүүгийн орлого төвлөрүүлдэг, торгууль ногдуулдаг байгууллага, хуулийн этгээдэд иргэд, төрийн бус байгууллага, хяналтын зөвлөлийн зүгээс 2023, 2024 оны хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтын ил тод байдалд үнэлгээ өгч, санал хүргүүлээгүй байна.

**БҮЛЭГ 4**

Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байгаагаас үр дүнг үнэлэх боломжгүй байна.

4.1. Хүү, торгуулийн орлогын бүртгэл мэдээллийн нэгдсэн сан байхгүй байна.**4.1.1. Байгууллага хооронд мэдээллийн нэгдсэн сан байхгүй байна.**

Хөгжлийн бодлого боловсруулах, макро эдийн засгийн төсөөлөл хийх, хөрөнгө оруулалт төлөвлөх ажлын хүрээнд судалгаа, тооцоо хийхэд шаардлагатай мэдээллийн нэгдсэн сан байгуулах харилцааг зохицуулсан “Засгийн газрын мэдээллийн нэгдсэн сан байгуулах, зохицуулах журам”-д мэдээллийн нэгдсэн санд төвлөрүүлэх мэдээллийн жагсаалтад хүү, торгуулийн орлогын мэдээллийг мэдээлэх талаар дурдаагүй байна.



Хүү, торгуультай холбоотой мэдээллийг нэгдсэн маягт, аргачлалаар бүртгэх боломжтой байгууллага хоорондын нэгдсэн мэдээллийн систем байхгүй байна.

Харин хүү, торгуулийн орлого төвлөрүүлэгч зарим байгууллагуудын хувьд дотооддоо ашигладаг мэдээллийн системтэй байна. Тухайлбал: Татварын газрын мэдээллийн системээр эрсдэлээ үнэлээд эрсдэл өндөртэй нэгжид хяналт шалгалт хийдэг байна.

Цагдаагийн газар нь “Цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн систем”-ээр бүртгэл мэдээллээ хөтөлдөг бөгөөд замын цагдаагийн бэлэн бусаар буюу x-cover төхөөрөмжийн тусламжтайгаар торгосон торгууль автоматаар бүртгэгдэж, бэлэн буюу шийтгэврийн хуудсаар торгосон торгуулийг Сангийн яамны баталсан маягтын дагуу торгосон эрх бүхий албан хаагч бүртгэл мэдээллийг системд хөтөлжээ. Түүнчлэн торгуулийн бүртгэл, мэдээллийг “ОД” программын тусламжтайгаар хяналтыг хэрэгжүүлдэг байна.

Салбарын хуулиудад мэдээллийн систем ашиглах чиглэлийг баримтлах талаар дараах байдлаар тусгажээ. Үүнд:

- Татварын ерөнхий хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэгт “Татварын алба татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сантай байна. Татварын алба чиг үүргээ хэрэгжүүлэх, мэдээлэл солилцох зорилгоор мэдээллийн систем, технологийг ашиглах бөгөөд тэдгээрийн нууцлал, найдвартай байдлыг бүрэн хангаж ажиллана” гэж заажээ. Тус хуульд татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд хамаарах мэдээлэлд татвар, алданги, торгуулийн бүртгэл гэж заажээ.
- Цагдаагийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1 дэх хэсэгт “Цагдаагийн байгууллага бүртгэл хөтөлж, мэдээллийн сүлжээ, сан үүсгэн үйл ажиллагаандаа ашиглана” гэж заажээ. Тус хуулийн бүртгэл хөтлөх мэдээлэлд зөрчил үйлдсэн этгээдийн талаар гэж заажээ.
- Гаалийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэгт “Гаалийн удирдах төв байгууллага нь энэ хуулийн 13.1-д заасан мэдээллийг гаргах зорилгоор гаалийн мэдүүлэгт үндэслэсэн гаалийн мэдээллийн санг бүрдүүлж, хөтөлнө” гэж заажээ. Гаалийн үйл ажиллагааны мэдээллийн сан нь энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан гаалийн статистикийн мэдээлэл,



түүнчлэн мөн хуулийн дагуу мэдүүлэгчээс гаалийн байгууллагад гаргаж өгсөн болон гаалийн байгууллагын өөрөө бүрдүүлсэн мэдээлэл, бичиг баримтаас бүрдэхээр тусгасан байна.

- Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 1-т “Мэдээллийн санг цахим хэлбэрээр бүрдүүлнэ” гэж заажээ. Мэдээллийн санд байгаль орчны холбогдолтой гэмт хэрэг, зөрчлийн мэдээллээс бүрдэнэ гэж тусгасан байна.
- Газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6 дахь хэсэгт “Энэ хуулийн 24.1-д заасан цогцолбор арга хэмжээг газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим систем /цаашид “цахим систем” гэх/-ээр дамжуулан хэрэгжүүлнэ”, 24.1 дэх хэсэгт “Газар зохион байгуулалт нь газрын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, газрын кадастр эрхлэх, газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, газрын эдийн засгийн чадавх, нөөцийг нэмэгдүүлэх, газар зүйн болон газрын харилцааны таатай орчин бүрдүүлэх зорилго бүхий цогцолбор арга хэмжээ мөн” гэж заасан байна.
- Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэгт “Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сан нь энэ хуулийн 6, 7, 8 дугаар зүйлд заасан улсын бүртгэлийн эх нотлох баримт бичгийн архив, цахим мэдээллийн сангаас бүрдэнэ” гэж заажээ. Улсын бүртгэлийн цахим мэдээллийн сан нь төрийн мэдээллийн бусад сантай мэдээлэл солилцох боломжтой байна.

Монгол Улс бие даасан төрийн мэдээлэл солилцооны системтэй болох, төрийн байгууллага хооронд мэдээлэл солилцох үйл ажиллагааг сайжруулах, хялбаршуулах, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор нээлттэй эхийн платформ дээр суурилсан, “Enterprise Service Bus” архитектуртай “ХУР” төрийн мэдээлэл солилцооны системийг хөгжүүлэн ажиллажээ. Энэхүү систем нь мэдээллийг илүү уян хатан шийдэлтэйгээр шуурхай, аюулгүй, найдвартай харилцан солилцуулах боломжийг бүрдүүлэхэд чиглэгдэж байна. Тиймээс энэхүү системд холбогдох боломжтой байдлаар дотооддоо ашигладаг системийн хөгжүүлэлт хийх нь чухал ач холбогдолтой байна.

4.1.2. Торгуулийн төлбөрийн системийн хэрэгжилт Цагдаагийн газар, Татварын газрын хувьд зохих түвшинд хангагдаж байна.

Хүү, торгуультай холбоотой мэдээллийг нэгдсэн маягт, аргачлалаар бүртгэх боломжтой байгууллага хоорондын нэгдсэн мэдээллийн систем байхгүй байна. Харин төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал Е-Монголиа систем, Ebarimt.mn цахим системүүдийг ашиглан зарим байгууллагын торгуулийн мэдээллийг лавлаж, төлөлт хийх боломжтой байна.

Аймгийн хэмжээнд 2023, 2024 онд ногдуулсан нийт торгуулийн 72.4 хувийг Цагдаагийн газар, 23.1 хувийг Татварын газар, 4.5 хувийг бусад байгууллага ногдуулсан байна.

Хүү, торгуулийн орлого төвлөрүүлэгч зарим байгууллагуудын хувьд системийн хэмжээнд дотооддоо ашигладаг мэдээллийн системтэй байна. Тухайлбал: Цагдаагийн газар нь системийн хэмжээнд “Цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн систем”-ээр бүртгэл мэдээллээ хөтөлдөг бөгөөд замын цагдаагийн бэлэн бусаар буюу x-cover төхөөрөмжийн тусламжтайгаар торгосон торгууль автоматаар бүртгэгдэж, бэлэн буюу шийтгэврийн хуудсаар торгосон торгуулийг Сангийн яамны баталсан маягтын дагуу торгосон эрх бүхий албан хаагч бүртгэл мэдээллийг системд хөтлөн оруулж, торгуулийн бүртгэл, мэдээллийг “ОД” программын тусламжтайгаар хянаж байна.



Татварын газар нь E-tax.mta.mn бүртгэл мэдээллээ хөтөлдөг бөгөөд, мэдээллийн систем нь эрсдэлээ үнэлээд эрсдэл өндөртэй нэгжид хяналт шалгалт хийж байна.

4.1.3. Зарим байгууллагын хяналтын систем нь орлого бүрдүүлэлтийн үр дүнд нөлөөлж байна.

Аймгийн хэмжээнд хүү, торгуулийн орлогын бүртгэл мэдээллийн нэгдсэн сан, хяналтын систем байхгүй байна. Хүү, торгуулийн орлого төвлөрүүлдэг байгууллагуудын хувьд өөр өөрсдөө бүртгэл хөтөлж байна.

Тухайн торгууль тавьсан эрх бүхий албан тушаалтнууд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хүрээнд тухайн торгуулийн барагдуулалтыг хариуцаж байна.

Аймгийн хэмжээнд 2023 онд 20 байгууллага, 2024 онд 18 байгууллага торгуулийн арга хэмжээ авсан бөгөөд торгуулийн орлогыг 2023 онд 17 байгууллага 100 хувь, 3 байгууллага 80.2-97.4 хувьтай, 2024 онд 15 байгууллага 100 хувь, 3 байгууллага 73.9-114.8 хувьтай төвлөрүүлсэн байна.

Торгуулийн орлогын бүрдүүлэлтийг 2023, 2024 оноор авч үзэхэд дунджаар 2023 онд 98 хувь, 2024 онд 98.6 хувийн биелэлттэй байна.

Зөрчлийн тухай хуулийн дагуу торгох шийтгэлийг хүлээж хугацаандаа биелүүлээгүй бол тухайн торгууль ногдуулсан байгууллага, эрх бүхий албан тушаалтан нь хуулийн байгууллагад хандаж шийдвэрлүүлж байна. Тухайлбал: Цагдаагийн газар бэлэн бусаар торгууль ногдуулснаар зөрчилд авах арга хэмжээг газар дээр нь шийдвэрлэж байгаа нь үр дүнтэй байгаа ч тухайн цаг хугацаандаа төлөлт нь хийгдэхгүй байх, он дамжин төлөгдөх асуудал гардаг байна. Цагдаагийн байгууллагын зүгээс иргэдэд мэдээлэл авах, төлбөрөө барагдуулах хяналтын систем нэвтрүүлсэн нь орлого бүрдүүлэлтийн үр дүнд эерэг нөлөөг үзүүлж байна.

Цагдаагийн байгууллагын торгуулийн төвлөрүүлсэн орлого 2023 онд 80.2 хувьтай байсан бол 2024 онд 114.8 хувь болж өссөн байна. Торгуулийн орлогын төвлөрүүлэлт өссөн нь Зөрчлийн тухай хуульд заасан торгох шийтгэлийн хэмжээг хөнгөлөх, нэмэгдүүлэх үндэслэл болон бусад хууль тогтоомжийн хүрээнд авч хэрэгжүүлсэн ажлын үр дүнгээр өмнөх оны барагдаагүй торгуулийн орлого төлөгдсөнөөс шалтгаалжээ.

Цагдаагийн газрын хувьд 2023, 2024 онд "torguuli.police.gov.mn" цахим хуудсанд бэлэн бус хэлбэрээр оногдуулсан торгуулийн мэдээлэл лавлах үйлчилгээ явуулж байсан бол 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс зогсоож доорх системүүдээр дамжуулан торгуулийн мэдээллээ лавлаж, төлөх боломжтой болсон байна. Үүнд:

- [Smartcar.mn](#) цахим хуудсаар дамжуулж торгуулийн мэдээллийг лавлаж, төлөлт хийх.
- Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал Е-Монголиа системээр дамжуулж өөрийн нэр дээрх болон тээврийн хэрэгслийн дугаар торгуулийн мэдээлэл лавлах, торгуулийн төлбөр төлөх.
- Цагдаа аппликейшн(102 Police). App store-с болон play store-с татах боломжтой.



- Төрийн банкны “Гялс банк” цахим хуудас, “Гялс банк үйлчилгээний смарт аппликейшн”-аар дамжуулж цахим хэлбэрээр төлөх.
- Голомт банкны “Интернет банк” цахим хуудсаар, “Смарт банк”, “SocialPay” гар утасны аппликейшнаар дамжуулж цахим хэлбэрээр төлөх.
- Гэрэгэ системийн үйлчилгээний төвүүдэд байрлах “Гэрэгэ киоск” машинаар дамжуулж төлөх. Мөн “Гэрэгэ аппликейшн”-ийг гар утсандаа суулгаж цахим хэлбэрээр төлөх www.gerege.mn
- Ebarimt.mn цахим төлбөрийн системээр дамжуулж торгуулийн мэдээллийг лавлаж, төлөлт хийх гэх мэт.

4.2. Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад эрх бүхий байгууллагуудаас тавих хяналт хангалтгүй байна.

4.2.1. Хугацаа хэтэрсэн, насжилт өндөртэй хүү, торгуулийн орлогыг барагдуулах ажлыг зохион байгуулж, дараагийн шатны арга хэмжээг авч ажилласан байна.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 2.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Энэ хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасан эрх бүхий албан тушаалтан хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд зөрчил шалган шийдвэрлэх явцад дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 1.12 дахь заалтад “Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд шийтгэл оногдуулсан шийдвэрийг тогтоосон хугацаанд биелүүлээгүй, зөрчлийн үр дагаврыг арилгахтай холбоотой зардлыг нөхөн төлөөгүй бол албадан гүйцэтгүүлэхээр шүүхэд хүсэлт гаргах” гэж заасны дагуу шүүхийн байгууллагад шилжүүлж байна.

Аудитын хүрээнд судалгаанд хамрагдсан байгууллагын 2023, 2024 онд ногдуулсан төлбөр болон төвлөрүүлсэн орлого дараах байдалтай байна.

Хүснэгт 19. Торгуулийн орлогын нэгтгэл

/мянган төгрөг/

Д/д	Орлого төвлөрүүлж байгууллагын нэр	Төслийн ангилал		2023 он					2024 он				
		Үүсний төсөвт	Орон нутгийн төсөвт	Ногдуулсан	Зөрчлийн тоо	Үүнээс			Ногдуулсан	Зөрчлийн тоо	Үүнээс		
						Төвлөрсөн	Илүү	Дутуу			Төвлөрсөн	Илүү	Дутуу
1	Увс аймаг дахь Газрын газар	3,950.0	-	400.0	4.0	410.0	-	-	3,550.0	13.0	3,550.0	-	-
2	Аймгийн Засаг даргын Тамгын газар	-	8,150.0	300.0	1.0	300.0	-	-	5,850.0	9.0	5,850.0	-	-
3	Улсын бүртгэлийн хэлтэс	20,550.0	-	9,300.0	415.0	9,300.0	-	-	11,250.0	550.0	11,250.0	-	-
4	Саяхуу төрийн сангийн хэлтэс	-	4,400.0	400.0	1.0	400.0	-	-	4,000.0	10.0	4,000.0	-	-
5	Улаангом сумын засаг даргын тамгын газар	-	200.0	-	-	-	-	-	200.0	1.0	200.0	-	-
6	Увс нуурын ай саянч улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа	500.0	-	500.0	1.0	500.0	-	-	-	-	-	-	-
7	Нийгмийн даатгалын газар	3,800.0	-	3,350.0	19.0	3,350.0	-	-	250.0	1.0	250.0	-	-
8	Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газар	2,300.0	-	1,400.0	5.0	1,400.0	-	-	900.0	3.0	900.0	-	-
9	Увс аймгийн Цагдаагийн газар	-	1,945,993.9	987,477.0	31,522.0	792,379.0	-	195,098.0	1,004,845.5	26,212.0	1,153,614.9	(148,769.40)	-
10	Боловсролын газар	-	-	-	-	-	-	-	4,000.0	2.0	4,000.0	-	-
11	Гадаадын иргэн харьяатын газар баруун бүс дэх газар увс аймаг дахь хэлтэс	-	1,980.0	120.0	3.0	120.0	-	-	1,860.0	12.0	1,860.0	-	-
12	Онцгой байдлын газар	-	9,400.0	1,000.0	10.0	1,000.0	-	-	8,400.0	6.0	8,400.0	-	-
13	Байгаль орчны газар	5,093.5	11,950.0	12,138.6	26.0	9,940.0	-	2,198.6	7,103.5	11.0	7,103.5	-	-
14	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар	-	7,800.0	600.0	2.0	600.0	-	-	8,300.0	22.0	7,200.0	-	1,100.0
15	Эрүүл мэндийн газар	5,500.0	2,100.0	5,300.0	8.0	5,300.0	-	-	2,300.0	5.0	2,300.0	-	-
16	Увс аймаг дахь ШШТ	-	250.0	250.0	1.0	250.0	-	-	-	-	-	-	-
17	Хүнс, хөдөө аж ахуйн газар	6,500.0	-	3,000.0	5.0	3,000.0	-	-	3,500.0	8.0	3,500.0	-	-
18	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	16,500.0	250.0	9,250.0	8.0	9,250.0	-	-	7,500.0	9.0	7,500.0	-	-
19	Увс аймгийн Мал эмнэлгийн газар	4,850.0	-	500.0	1.0	500.0	-	-	4,350.0	12.0	4,350.0	-	-
20	Увс аймгийн Автозастрийн төв	3,990.0	5,140.0	4,440.0	81.0	4,440.0	-	-	4,690.0	47.0	4,690.0	-	-
21	Архивын газар	-	300.0	300.0	1.0	300.0	-	-	-	-	-	-	-
22	Төлвөрийн газар	-	524,124.7	226,732.5	38.0	220,824.8	-	5,907.7	410,192.5	36.0	303,300.0	-	106,892.5
Нийт дүн		73,333.5	2,520,938.6	1,266,756.1	32,152.0	1,063,563.8	-	203,284.3	1,483,041.5	26,968.0	1,533,818.4	(148,769.4)	107,992.5

Эх сурвалж: Аудитын хүрээнд авсан нэгтгэл судалгаа



Судалгаанаас харахад 2023 онд Цагдаагийн газар 195,098.0 мянга, Татварын газар 5,907.7 мянга, Байгаль орчны газар 2,198.6 мянга, нийт 203,804.3 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн, 2024 онд Татварын газар 106,892.5 мянга, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар 1,100.0 мянга, нийт 107,992.5 мянган төгрөг дутуу, Цагдаагийн газар 148,769.4 мянган төгрөг илүү төвлөрүүлсэн байна.

Дээрх дутуу төвлөрүүлсэн орлогоос Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар 1,100.0 мянган төгрөгийн торгуулийн зөрчлийг барагдуулах ажил зохион байгуулаагүй, дараагийн шатны арга хэмжээ аваагүй байна. Барагдуулаагүй торгууль 1,100.0 мянган төгрөгийн зөрчилд дараагийн шатны арга хэмжээ авч ажиллахыг зөвлөлөө.

Цагдаагийн газрын хувьд 2024 онд торгуулийн орлого 148,769.4 мянган төгрөгөөр илүү төвлөрүүлсэн нь өмнөх оны барагдаагүй торгуулийн орлогыг төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Увс аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас ирүүлсэн тоон мэдээллээс үзвэл 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар Зөрчлийн тухай хуулийн дагуу торгох шийтгэлийг хүлээж хугацаандаа биелүүлээгүйн улмаас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраар 2020 оноос хойш албадлагын арга хэмжээ авч дууссан 1344 иргэн, хуулийн этгээдийн 914,103.3 мянган төгрөгийн төлбөр, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж байгаа 35 иргэн, хуулийн этгээдийн 365,327.4 мянган төгрөгийн төлбөр байна.

4.2.2. Төрийн аудитын газраас Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын зарцуулалтад хяналт хэрэгжүүлсэн, бусад эрх бүхий байгууллагын зүгээс хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт хэрэгжүүлээгүй байна.

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт “Төсвийн орлого нь татварын орлого, татварын бус орлогоос бүрдэнэ”, 23.3 дах хэсэгт “Татварын бус орлого нь төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн болон орон нутгийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг, төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр, төрийн болон орон нутгийн өмчийг түрээсэлсний орлого, **торгуулийн орлого**, төсвийн байгууллагын туслах үйл ажиллагааны орлого, Засгийн газрын зээллэг, тусламж болон хууль тогтоомжийн дагуу төсөвт төвлөрүүлэх бусад орлогоос бүрдэнэ” гэж заасан байна.

Торгууль ногдуулах эрх бүхий байгууллага, албан тушаалтан торгуулийн орлогыг улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлж байна.

Зураг 7. Төвлөрүүлсэн орлого, төсвийн ангиллаар, хувиар



Эх сурвалж: Аудитын хүрээнд авсан нэгтгэл судалгаа



Улс, орон нутгийн төсөвт 2023, 2024 онд нийтдээ 2,586,622.1 мянган төгрөгийн торгуулийн орлого төвлөрүүлснээс 2,519,788.6 мянган төгрөг буюу 97.4 хувь нь орон нутгийн төсөвт, 66,833.5 мянган төгрөг буюу 2.6 хувь нь улсын төсөвт төвлөрчээ.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.36 дахь заалтад "Төсвийн ерөнхийлөн захирагч" гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, **хяналт тавих**, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг", 4.1.37 дахь заалтад "Төсвийн төвлөрүүлэн захирагч" гэж төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг", Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт "Аймгийн чиг үүрэгт дараах асуудал хамаарна", 21.1.3 дахь заалтад "Аймгийн төсөв, түүний төлөвлөлт, гүйцэтгэл, тайлан, хяналт, 22.1 дэх хэсэгт "Сумын чиг үүрэгт дараах асуудал хамаарна", 22.1.3 дахь заалтад "Сумын төсөв, түүний төлөвлөлт, гүйцэтгэл, тайлан, хяналт" гэж заасан байна.

Аймаг, сумдын торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт болон хүү, торгуулийн орлого төвлөрүүлэгч байгууллага, Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдэд 2023, 2024 онд тусгай хөтөлбөр, удирдамжийн хүрээнд хяналт шалгалт хийгээгүй байна.

Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хуулийн хүрээнд хяналт хэрэгжүүлэхийг зөвлөмж болгов.

Хүү, торгуулийн орлогоор санхүүжүүлэх зардлаас Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хууль тогтоомжийн хүрээнд зардал хуваарилж байна.

Төрийн аудитын байгууллагаас Төсвийн тухай хуульд заасан цаглаврын дагуу Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланд аудит хийхдээ хүүгийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт хэрэгжүүлж байна.

Мөн Төрийн аудитын байгууллагаас төсвийн шууд захирагчдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын батлагдсан төсвийн гүйцэтгэлд жил бүр санхүүгийн тайлангийн аудитаар горим сорил хэрэгжүүлэн ажилладаг бөгөөд 2023 онд зориулалт бус зарцуулалттай холбоотой 2,500.0 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт, 2024 онд анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй 1,000.0 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өгсөн байна.

4.2.3. Орлого төвлөрүүлэгч байгууллагууд нь торгуулийн орлогод дотоод хяналт хэрэгжүүлээгүй байна.

Торгууль ногдуулах эрх бүхий байгууллага, албан тушаалтан торгуулийн орлогыг улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлдэг бөгөөд хууль, эрх зүйн зохицуулалтаар торгуулийн орлогыг төвлөрүүлэгч байгууллага нь зарцуулах эрх хэмжээ байхгүй байна.

Торгуулийн орлогын бүрдүүлэлтэд 2023, 2024 онд тусгай хөтөлбөр, удирдамжийн хүрээнд дотоод хяналт хэрэгжүүлсэн байгууллага байхгүй байна.



Харин Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасан эрх бүхий албан тушаалтан хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд зөрчил шалган шийдвэрлэх явцад хуулиар харьяалуулсан зөрчилд шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ авах, зөрчлийн үр дагаврыг арилгах арга хэмжээ авах, зардлыг нөхөн төлүүлэх, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд шийтгэл оногдуулсан шийдвэрийг тогтоосон хугацаанд биелүүлээгүй, зөрчлийн үр дагаврыг арилгахтай холбоотой зардлыг нөхөн төлөөгүй бол албадан гүйцэтгүүлэхээр шүүхэд хүсэлт гаргах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу орлого төвлөрүүлэгч байгууллагуудын торгууль ногдуулсан эрх бүхий албан тушаалтан зөрчилд тавигдсан торгуулийг өөрөө хариуцан хэрэгжилтийг хангуулах ажиллагааг явуулж байна.

4.2.4. Хөндлөнгийн байгууллагаас хяналт хэрэгжүүлээгүй байна.

Аймгийн торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт болон хүү, торгуулийн орлого төвлөрүүлэгч байгууллага, Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдэд хөндлөнгийн байгууллагуудаас /Иргэн, ТББ, ОУБ, Зөвлөл г.м/ хяналт хэрэгжүүлээгүй байна.



ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Хүүгийн орлого төвлөрүүлдэг төсвийн байгууллага, Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүд хүүгийн орлогыг төлөвлөөгүй, торгуулийн орлогыг төлөвлөхдөө суурь судалгаа, өмнөх оны гүйцэтгэлд үндэслээгүй байна.
2. Ногдуулсан торгуулийн орлогыг төсөвт 98.3 хувьтай төвлөрүүлсэн байна.
3. Хүү, торгуулийн орлогыг санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд үнэн зөв тусгасан байна.
4. Хүү, торгуулийн орлогоос Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хуваарилсан зардлыг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулсан байна.
5. Аймаг, сумдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс үйл ажиллагааны тайлангаа олон нийтэд мэдээлсэн байна.
6. Хүү, торгуулийн орлогын бүртгэл мэдээллийн нэгдсэн сан байхгүй, байгууллагууд өөрсдөө бүртгэж байна.
7. Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байна.



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



**УВС АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН АЖЛЫН АЛБА**

3 дугаар баг, Улаангом, Увс аймаг, 85166

Утас/Факс: 7045-2113

Цахим шуудан: info@khural.uv.gov.mn

Цахим хуудас: www.uvs.khural.mn


2025.07.08 № 181

танай _____ -ны № _____ -т

**АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
М.БАТСУУРЬ ТАНАА**

Аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.
Төсөлд тусгах санал байхгүй болно.

ДАРГЫН ҮҮРГИЙН ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ч.ЭНХБАЯР



0515010112



МОНГОЛ УЛС
УВС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

3 дугаар баг, Улаангом, Увс аймаг, 85165

Утас: 7045-2315 Факс: 7045-4095

Цахим шуудан: info@uvs.gov.mn

Цахим хуудас: www.uvs.gov.mn

2025.07.21 № 1/1301

танай _____ -ны № _____ -т

УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

“Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Дүгнэлт хэсгийн нэгдүгээр заалт нь улсын төсвийн байгууллага, арилжааны банкинд данстай төсөвт үйлдвэрийн газар болон төрийн өмчит компаниудад хамаардаг тул аймгаас тус орлогыг урьдчилан төлөвлөх боломжгүй байдаг. Иймд холбогдох байгууллагад нь чиглэлийг өгч, энэхүү дүгнэлтээс хасна уу.

Торгуулийн орлого нь татварын бус орлого бөгөөд иргэд, аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд ачаалал үүсгэхгүй байх үүднээс урьдчилан тооцох боломжгүйг анхаарч үзнэ үү.

Торгуулийн орлогоос гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хуваарилах зардлыг сангийн яамны суурь тоо болон өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн хууль журмын дагуу хуваарилдаг.

Иймд зөвлөмжийн 1 дүгээр заалтыг эргэж харна уу.




С.БАТЖАРГАЛ

D disk: AZDTG_zasaq-5

8525020713



АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР М.БАТСУУРЬ ТАНАА

Тус цагдаагийн газраас "Хүү, торгуулийн орлогын
бүрдүүлэлт, зарцуулалт"-ын гүйцэтгэлийн аудитын
тайлангийн төсөлд нэмж тусгуулах санал байхгүй
болно.

ДАРГА, ЦАГДААГИЙН
ДЭД ХУРАНДАА

М.АЛТАНБАГАНА

480^000^91



УВС АЙМАГ
ТАТВАРЫН ГАЗАР

3 дугаар багс Улаангом, Увс аймаг, 85165

Утас/Факс: 7045-3849

Цахим шуудан: Uvs@mta.gov.mn

Цахим хуудас: www.mta.gov.mn

2025 09.09 № 195
Танай _____ -ны № _____ -г

УВС АЙМГИЙН ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Танай байгууллагаас 2025 оны 07 дугаар сарын 08-ний өдөр ирүүлсэн хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Манай байгууллагаас тус төсөлд хүргүүлэх санал байхгүй байна.

ДАРГА  М. ГАЛСҮРЭН

8525110417



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН ИРҮҮЛСЭН САНАЛД ӨГӨХ ТАЙЛБАР

Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хийсэн аудитын тайлангийн төсөлд ирүүлсэн саналд дараах хариуг хүргүүлж байна.

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 181 дүгээр албан бичгээр, Цагдаагийн газрын 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 48/2866 дугаар албан бичгээр, Татварын газрын 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 195 дугаар албан бичгээр тус тус тайлангийн төсөлд тусгуулах санал байхгүй гэсэн хариу ирүүлсэн тул тайлангийн төсөлд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.
2. Аймгийн Засаг даргын 2025 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 1/1301 дүгээр албан бичгээр дараах санал ирүүлсэн байна. Үүнд:
 - ✓ Саналд “Дүгнэлт хэсгийн 1 дүгээр заалт нь улсын төсвийн байгууллага, арилжааны банканд данстай Төсөвт үйлдвэрийн газар болон Төрийн өмчит компаниудад хамаардаг тул аймгаас тус орлогыг урьдчилан төлөвлөх боломжгүй байдаг. Иймд холбогдох байгууллагад нь чиглэлийг өгч энэхүү дүгнэлтээс хасна уу” гэжээ. Ирүүлсэн саналын дагуу тайланд өөрчлөлт орууллаа.
 - ✓ Саналд “Торгуулийн орлогоос гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хуваарилах зардлыг Сангийн яамны суурь тоо болон өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн хууль, журмын дагуу хуваарилдаг. Иймд зөвлөмжийн 1 дүгээр заалтыг эргэж харна уу” гэжээ. Ирүүлсэн саналын дагуу тайланд өөрчлөлт орууллаа.
 - ✓ Саналд “Торгуулийн орлого нь татварын бус орлого бөгөөд иргэд аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд ачаалал үүсгэхгүй байх үүднээс урьдчилан тооцоолох боломжгүйг анхаарч үзнэ үү” гэжээ. Торгуулийн орлогыг тухайн байгууллага төлөвлөдөггүй ч аймгийн хэмжээнд жил бүр төлөвлөхдөө ямар нэгэн тооцоо судалгаагүйгээр төлөвлөж байгаа талаар тайланд тодорхой тусгасан тул тайлангийн төсөлд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

**ЗӨВЛӨМЖ**

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөмж болгож байна. Үүнд:

Аймгийн Засаг даргад:

1. Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хуулийн хүрээнд хяналт хэрэгжүүлэх.

Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэст:

1. Торгуулийн орлогыг тооцоо, судалгаа, өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн төлөвлөж байх.

Үндэсний аудитын газрын нэгтгэл тайланд тусгуулахаар уламжлах санал:

1. Зөрчлийн тухай хуулийн 7.11 дүгээр зүйлийн 7.11.3-т “Үнэт металл, эрдэнийн чулууны сорьц, чанарыг тогтоолгох, эсхүл бүртгүүлэх журам зөрчсөн бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж заасан нь Сорьцын хяналтын улсын байцаагчийн шийдвэрлэх хэргийн харьяалалд хамаарахаар байхад Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.42-т энэхүү зөрчлийг геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч шалгах шийдвэрлэхээр заасныг Сорьцын хяналтын улсын байцаагч шалган шийдвэрлэх болгон өөрчлөх талаар тусгуулах.
2. Захиргааны ерөнхий хуулийн 85 дугаар зүйлийн 85.2 дахь хэсэгт “Захиргааны шийдвэрээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй этгээдэд захиргааны байгууллага хуульд заасан журмын дагуу албадлага хэрэглэнэ” гэж заасанд нийцүүлэн албадлагыг ямар хэлбэрээр явуулах талаар холбогдох хууль тогтоомжид нарийвчилсан зохицуулалтыг тусгуулах.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

М.БАТ-АМГАЛАН

ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР



Т.НАМЖИЛ

Ч.МӨНХТОГТОХ

Т.АМАРМЭНД

Б.НЯМБУУ

Т.АРИУНСАЙХАН

Л.ШАГДАРСҮРЭН

Увс аймаг, Улаангом-85160.

Засаг даргын тамгын газрын байр Утас:70453317

И-мэйл: uvs@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn